



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН

МОНИТОРИНГИЙН ГАРЫН АВЛАГА



ИИ.МН
СЭДАЛ ААНЫ САН

Улаанбаатар 2007

DDC
361, 25'023
M-698

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, хувилахыг хүсвэл
Нээлттэй Нийгэм Форумын хаягаар хандан зохих зөвшөөрөл авна уу.

ХАЯГ:
Жамъян Гүний гудамж -5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48
Монгол Улс
Утас: 976 - 11 - 313207
Факс: 976 - 11 - 324857

Гарын авлагыг сонирхсон байгууллага хувь хүмүүст
хямдралтай үнээр худалдана.

ISBN 978-99929-2-037-8

ОИИ.МН
СУДАЛГААНЫ САН

ӨМНӨТГӨЛ	4
МОНИТОРИНГ ГЭЖ ЮУ ВЭ?	6
Мониторинг цогц үйл ажиллагаа болох нь	6
Сайн засаглал ба мониторингийн ач холбогдол	7
МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?	10
Юунд мониторинг хийх вэ?	10
Мониторинг хийхэд мэдээлэл ямар үүрэгтэй вэ?	10
Мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зарим зүйл	11
Мониторингийн төслийн үе шат	14
Мониторинг хийх асуудлыг сонгох	15
Суурь судалгаа	17
Мониторингийн аргачлал	20
Анхдагч мэдээлэл цуглуулах аргууд	23
Анхдагч мэдээлэл цуглуулах арга хэлбэрүүдийн сул болон давуу талууд	32
Мэдээллийг баримтжуулж баталгаажуулах	35
Мэдээллийг боловсруулах, нэгтгэн дүгнэх	36
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН	40
НӨЛӨӨЛӨЛ	46
Нөлөөлөл гэж юу вэ?	46
Нөлөөллийн үе шатууд	46
Нөлөөллийн явцыг хянах, дүгнэх	56
Ашигласан ном, материал	66

ӨМНӨТГӨЛ

Ардчиллын зарчимд бат суурилсан, авилга, хүнд суртлаас ангид, хариуцлагатай, ил тод засаглалыг төлөвшүүлэн бэхжүүлэхэд иргэдийн идэвхтэй оролцоо нэн чухал билээ. Нээлттэй Нийгэм Форумгаас иргэний нийгмийн энэхүү оролцоог дэмжих үүднээс 2005 оноос эхлэн төрийн бус байгууллагуудад зориулан төр засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэхүү тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын туршлагатай багш, зөвлөх нарын оролцоотой зохион байгуулсан цуврал сургалт болон өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төслүүдийн туршлагыг нэгтгэн иргэний нийгмийн зүгээс төрийг хянах нэг чухал хэрэгсэл болох мониторингийн талаарх гарын авлага хэвлэснээ Танд өргөн барьж байна.

Энэхүү гарын авлага нь мониторингийн тухай үндсэн ойлголт, мониторинг хийх аргачлал, түүний гол үр дүн болох тайланг бичих, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар өгүүлэх бөгөөд энгийн ойлгомжтой ашиглахад хялбар болсон байх хэмээн найдаж байна.

Иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээдэг, ил тод төрийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахаар хичээн зүтгэж буй хэн бүхний үйл хэрэгт энэхүү гарын авлага тус болох буй за.

Гүйцэтгэх захирал



П.Эрдэнэжаргал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**МОНИТОРИНГ ГЭЖ
ЮУ ВЭ?**



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНИТОРИНГ ГЭЖ ЮУ ВЭ?

Ардчилал хөгжсөн нийгэмд төрийн бус байгууллага (ТББ) нь иргэдийн дуу хоолой болон тэдний эрх ашгийг төлөөлдөг нийгмийн чухал институци болдог. Энэ утгаараа ТББ нь дараахь түгээмэл үүргийг гүйцэтгэдэг байна:


1. Төрөөс иргэдэд хүргэж чадахгүй байгаа хүмүүнлэгийн, нийгмийн болон байгаль орчныг хамгаалах гэх мэт үйлчилгээг хүргэх;
2. Хууль тогтоох, мөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд төрийн байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх;
3. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрт хөндлөнгийн хяналт тавих, хүний эрх, иргэдийн тодорхой хэсгийн ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалах;
4. Иргэдэд бүх талын, бодитой мэдээлэл түгээх, ил тод байдлыг хангах;
5. Иргэдийг гэгээрүүлэх, тэдэнд ардчиллын үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд тус дэм үзүүлэх зэрэг болно.

ТББ-ын гүйцэтгэх эдгээр үүргүүдээс хэд хэдийг нь нэгтгэсэн үйл ажиллагааны нэгэн цогц хэлбэр бол мониторинг юм. Дэлхийн олон оронд иргэний нийгмийн байгууллагууд нь мониторингийн аргыг хүний эрхийн зөрчил, авилга, хүнд суртал гэх мэт төрийн бодлого, үйл ажиллагааны янз бүрийн гажуудалтай тэмцэн хариуцлага тооцоход чухал хэрэгсэл болгон түгээмэл хэрэглэсээр иржээ. Үүнтэй холбоотойгоор гарсан “watchdog function” буюу Монгол хэлэнд үгчилэн хөрвүүлбэл “хоточ нохой”-н үүрэг нь иргэний нийгмийн байгууллагуудын байнга гүйцэтгэдэг үйл ажиллагааны салшгүй нэг хэлбэр болон заншсан байдаг.

Мониторинг цогц үйл ажиллагаа болох нь

Мониторинг гэдэг нь иргэний нийгмийн зүгээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, гаргаж буй бодлого, шийдвэр, тэдгээрийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих замаар алдаа дутагдал, гажуудлыг нь олж тогтоон, хөдөлшгүй баримттайгаар дэлгэн үзүүлэх, улмаар тухайн асуудал, нөхцөл байдалд нийгмийн анхаарлыг хандуулж, хэрхэн засаж залруулах талаар зөвлөмж боловсруулан засаглалын хүрээнд бодлого боловсруулах, гүйцэтгэх төвшинд нөлөөлөх арга хэмжээ авах цогц үйл ажиллагаа юм.

Товчоор хэлбэл мониторинг нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.



Мониторинг хэмээх хэсэгт дараах үйл ажиллагааг хамруулан ойлгож болно:

- Төрөөс баталсан бодлого, түүний хэрэгжилт, иргэдэд төрөөс үзүүлж буй үйлчилгээний талаар системтэй баримт мэдээлэл цуглуулах. Ингэхдээ:
 - Мониторинг хийхээр сонгосон тодорхой асуудал буюу тухайн нөхцөл байдлыг нийтлэг тогтсон стандарт эсвэл хуульчлагдсан хэм хэмжээтэй харьцуулан үнэлэх замаар зөрчил, гажуудлыг илрүүлэх;
 - Хууль, дүрэм журам, шийдвэр, бодлого хэрэгжүүлэх тогтолцоо, үйл ажиллагааны зарчим зэрэг нь үйлчлэхгүй буюу хэрэгжихгүй байгааг баримттай илрүүлэх, зөрчлийн голомт, учир шалтгаан нь хаана байгааг тогтоох.

Үр дүнг мэдээлэх гэсэн хэсэгт дараах үйл ажиллагаа багтана:

- Мониторингийн явцад шаардлагатай үед илрүүлсэн баримт мэдээллийг хэвлэлийн бага хурал зохион байгуулж нийтэд хүргэх, хэвлэлийн мэдээлэл /press release/ сэтгүүлчдэд түгээж нийтлүүлэх
- Мониторингийн үр дүнг танилцуулсан тайлан гаргах, түүндээ мониторингийн асуудалд өгсөн үнэлгээ, цаашид хийвэл зохих ажлын талаар зөвлөмж боловсруулан оруулах.

Нөлөөлөл гэсэн хэсэгт дараах үйл ажиллагаа багтана:


- Мониторингийн мэдээлэл, зөвлөмжид үндэслэн илэрсэн зөрчлийг засаж залруулах талаар тодорхой стратегид тулгуурласан цогц үйл ажиллагаа явуулах.



Сайн засаглал ба мониторингийн ач холбогдол

Мониторингийн үндсэн ач холбогдол нь иргэний нийгмийн зүгээс төр засгийн бодлого, үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих замаар ардчилсан сайн засаглал бүрэлдэн хөгжихөд хувь нэмэр оруулах явдал мөн. Эндээс сайн засаглал гэсэн ойлголтыг дэлгэрэнгүй тайлбарлах нь зохистой.


Сайн засаглал нь дараах гол зарчмуудад тулгуурласан байх ёстой бөгөөд төр засаг нь шийдвэр гаргах, хэрэгжүүлэх явцдаа эдгээр зарчмуудаас хазайх ёсгүй. Үүнд:



- Хууль дээдлэх
- Ил тод байдлыг хангах
- Ижил тэгш бололцоог бүрдүүлэх
- Шударга ёс ба тэгш эрхийг дээдлэх
- Иргэдийн оролцоог дэмжих, тэдэнтэй зөвшилцөх
- Иргэдийн нийтлэг эрх ашгийг эрхэмлэх, тэднийг төлөөлөх
- Хариуцлагатай байдлыг хангах
- Үр ашиг, үр дүн

Төрийн зүгээс, шийдвэр гаргах болон тэдгээрийг хэрэгжүүлэх явцдаа эдгээр зарчмуудыг хэрхэн баримталж байгааг иргэний нийгмийн байгууллага хөндлөнгөөс хянахад мониторинг нь чухал хэрэгсэл болдог.

МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ВЭ?

Юунд мониторинг хийх вэ?

Мониторинг хийхэд ТББ нь өөрийн чадавхи, нөөц бололцоо, хуримтлуулсан туршлага зэрэгтээ нийцүүлэн тодорхой чиглэл буюу асуудлыг сонгон авах нь үр дүнтэй юм. Гэвч иргэдийн эрхийг ноцтой хөндсөн, сайн засаглал, ардчиллын зарчмыг илэрхий гажуудуулсан асуудал хараанд өртсөн тохиолдолд түүнийг орхигдуулж болохгүй нь ойлгомжтой. Мониторинг хийх шаардлага гарч болох магадлал бүхий аливаа хэлбэрийн гажуудалд “өртөмтгий” зарим нэг жишээг дурдвал:

- Шинэ хууль, тогтоомжуудын хэрэгжилтийн үйл явц. Жишээ нь: Авилгын эсрэг хууль
- Авилгад өртөх сэжиг магадлал ихтэй нэг удаагийн үйл явц. Жишээ нь: хувьчлал
- Авилгад байнга өртөмтгий үйл явц. Жишээ нь: сонгуулийн санхүүжилт, тендер, тусгай зөвшөөрлийн лиценз олголт, газар хувьчлал гэх мэт
- Хүнд суртал, хариуцлага сул байх магадлал өндөртэй төрийн үйлчилгээ. Жишээ нь: халамжийн үйлчилгээ
- Олныг шуугиулсан үйл явдлаар илэрсэн ноцтой асуудлууд гэх мэт.

Мониторинг хийхэд мэдээлэл ямар үүрэгтэй вэ?

Мониторинг хийхэд төрийн байгууллагуудаас бодитой мэдээлэл олж авах нь гол асуудал байдаг.



Монгол Улсын Үндсэн хуулийн 16 зүйлд зааснаар иргэд “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй...” түүнчлэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэжээ.


Глоб Интернэшнл ТББ-ын мэдээллийн эрх чөлөөний талаар хийсэн судалгааны дүгнэлтэд өгүүлснээр төрийн байгууллагуудын зүгээс “нууц” гэсэн ангиллын доор аливаа зүйлийг олон нийтээс нууцалж иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг зөрчих явдал газар авсан бөгөөд энэ байдал нь эргээд төрийн албан хаагчдын дунд хариуцлага сулрах шалтгаан болж байгаа талаар дурджээ. Иймд ТББ нь мониторинг хийхдээ Монгол улсын иргэн нь ямар мэдээлэл төрийн

байгууллагаас авах эрхтэй болох ямар мэдээлэл нь төрийн нууцад хамаарах талаар сайтар мэддэг байх шаардлагатай.

Мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд анхаарах зарим зүйл

Мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд юуны өмнө ямар салбар чиглэлээр мониторинг хийх талаараа хэлэлцэн шийдвэрлэж, үр дүн, хэтийн зорилгоо тодорхойлох хэрэгтэй. Үүн дээр үндэслэн ойрын зорилтуудаа тодорхойлж, зорилт тус бүрт хүрэхийг эрмэлзэн цаашид авах арга хэмжээ, үйл ажиллагаагаа нарийн цэгцтэй төлөвлөх нь чухал юм.

Үүнийг зорилгод тулгуурласан төслийн төлөвлөгөө гэх бөгөөд ийм төлөвлөгөө хэрхэн боловсруулах талаар тусдаа аргачлал байдаг. Зорилгод тулгуурлан төсөл төлөвлөхөд зарим нэр томъёо, тэдгээрийн утгыг ялгаж салгаж ойлгох нь нэн тэргүүний асуудал юм.



Зорилго: Төслийн үр дүнд хүрэхээр төлөвлөж буй хэтийн ирээдүй бөгөөд үр дүн, үр нөлөө гэж дотор нь нарийвчлан хувааж болно.

- **Зорилт:** Зорилгод хүрэхийн тулд тавьсан ойрын зорилтууд бөгөөд хэмжиж болохуйц байна.

Жишээ:

Олон улсын нэгэн байгууллагаас төрийн удирдлагын тогтолцооны төвлөрлийг сааруулах хэтийн **зорилготой** төсөл хэрэгжүүлэхэд дараах гол **зорилтуудыг** дэвшүүлжээ. Үүнд: төрийн удирдлагатай холбоотой хууль эрх зүйн орчинд зохих өөрчлөлт оруулах болон орон нутгийн удирдлагад төсвийн тодорхой хувийг төвлөрүүлэн удирдах эрх олгоход нөлөөлөх. Тус байгууллагаас дээрх зорилтуудад хүрэхийг эрмэлзэн хэд хэдэн **үйл ажиллагаа** төлөвлөсний дотор орон нутагт төвлөрөлийг бодитой сааруулах бололцооны талаар судалгаа хийх, судалгааны үр дүнд үндэслэн төвлөрлийг хэрхэн сааруулах талаар санал боловсруулан эрх баригчдад өргөн барих гэх мэт үйл ажиллагаа багтжээ.

Аливаа төслийн амжилттай хэрэгжих эсэх нь үр дүнтэй зохион байгуулалт, үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт, төсвийн зохистой хуваарилалт, тэдгээрийг хэрхэн алдалгүй дагаж мөрдөхөөс шууд хамааралтай байдаг.

Энэ нь ч мөн мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд хамаатай асуудал юм. Тогтоосон цаг хугацаанд багтаан тодорхой зорилго, зорилтуудад хүрэхээр

эрмэлзэж үйл ажиллагаагаа хамгийн зөв зохистой явуулахад зохион байгуулалтын асуудлыг нарийн шийдэж төлөвлөх нь чухал юм. Үүнд мониторинг гүйцэтгэхэд шаардагдах цаг хугацаа, хүн хүч, төсөв санхүүгийн холбогдолтой асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай тусгаж оруулна.

Мониторинг төлөвлөх, хамрах цар хүрээг тогтоох, аргачлалаа боловсруулахдаа өөртөө байгаа нөөц бололцоог харгалзан дараах асуултуудад хариулах замаар төлөвлөгөөгөө боловсруулах нь зүйтэй.

- хэн ямар тодорхой үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэх
- үйл ажиллагаанд хэр хугацаа шаардлагатай болох
- ямар хөрөнгө төсөв шаардагдах (энэ төсвийн хэдэн хувийг байгууллага хариуцах, сайн дурын оролцогчдоор гүйцэтгүүлэх боломж байгаа эсэх, шаардлагатай зардлууд, ямар эх үүсвэрээс энэ мөнгийг олж авах гэх мэт асуудлууд энд орно.)



Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө

Мониторингийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө чухал бөгөөд үүнд шаардагдах ажлуудыг жагсаан, хариуцах хүнийг томилж, хэзээ гүйцэтгэх хуваарийг гаргасан байна. Үйл ажиллагааны энэхүү төлөвлөгөөг мониторингийн багийн гишүүд хэрхэн биелүүлж байгааг хянах нь төслийн удирдагчийн гол үүрэг нь байдаг.


Төлөвлөгөөг боловсруулахдаа ямарваа тэмдэглэлт болон улс төрийн үйл явдал хэзээ болох, тэр нь мониторингийн явцад саад учруулж болох эсэхийг харгалзах нь зүйтэй.

Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө хийх загвар:

Зорилт	Үйл ажиллагаа	Гүйцэтгэх Ажил	Хариуцах хүн	Төсөв	Хугацаа								
					I				II				
					01	02	03	04	01	02	03	04	
1	1.1.	1.1.1.											
		1.1.2.											
	1.2.	1.2.1.											
		1.2.2.											
2	2.1.	2.1.1.											
		2.1.2.											
	2.2.	2.2.1.											
		2.2.2.											

Хельсинкийн “Хүний эрхийн сан”-гаас гаргасан “Хүний эрхийн мониторингийн гарын авлага”-д дурьдсанаар мониторингийн төсөв төлөвлөхөд дараах хэдэн зүйлийг санахад илүүдэхгүй гэжээ. Үүнд:

- Мониторинг нь төсөл санаачлан, гүйцэтгэх байгууллага болон хүмүүсийн санхүүгийн бэрхшээлийг шийдэх арга хэрэгсэл болж таарахгүй. Иймд зөвхөн төсөлд шаардагдах хөрөнгийг бодитой тусгах нь чухал.
- Төслийг санаачлан гүйцэтгэх байгууллага болон хүмүүсийн өөрсдийн оруулж чадах хувь нэмрийг тооцох
- Төслийн хүрээнд тавьсан зорилтыг харгалзан үзээд хэтэрхий их хөрөнгө мөнгө шаардсан үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах буюу боломжтой гэж үзвэл хасах.

 **Төсөв**
Аливаа төслийн үнэ цэнийг түүнийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулан дүгнэдэг. Тиймээс төсөл төлөвлөхөд аль болох бага хүч, зардлаар сайн үр дүнд хүрэх зарчмыг баримтлах ёстой. Төслийн санхүүжилтэд дэмжлэг авах хүсэлт тавихад санхүүжүүлэгч байгууллагууд нь мөнгөний хэмжээг төслөөс гарах үр дүнтэй байнга харьцуулдаг.

Тактикийн асуудал




Мониторингийн төсөл хэрэгжүүлэхэд үйл ажиллагаатай холбоотой тактикийн зарим асуудал урган гарах магадлалтай. Ямар тактик баримтлах нь тухайн төслийн онцлогоос шалтгаална. Тухайлбал, мониторинг хийхэд зарим байгууллагын дээд албан тушаалтнуудын дэмжлэгийг олж авах шаардлага гарч болно. Энэ тохиолдолд тэдэнд албан бичиг буюу захидал илгээн байгууллагаа танилцуулахын зэрэгцээ мониторингийн ач холбогдлыг тайлбарлан таниулах нь чухал. Тухайлбал, захидлаар дамжуулан мониторингийн зорилго нь тухайн байгууллага албан тушаалтныг шалган, дайрч давшлах зорилготой бус, холбогдох нөхцөл байдлыг сайжруулах явдал гэдгийг зөв, ойлгомжтой тайлбарлах нь зүйтэй. Төслийн тайланг тэдэнд хамгийн түрүүнд хүргэнэ гэдгээ дурьдах хэрэгтэй.

Тодорхой асуудал сонгон мониторинг хийж дууссаны дараа үр дүнг тооцох нь зайлшгүй чухал. Мониторингийн төслийн амжилтыг дараах хэмжигдэхүүнийг ашиглан тооцно:

- **Гарц:** үйл ажиллагааны үр дүнд үүссэн бүтээгдэхүүн (зорилтууд биелсэн байна)
- **Үр дүн:** бүтээгдэхүүнээс үүдэлтэй бий болсон бодит ахиц
- **Үр нөлөө** (зорилгод хүрсэн байна)

Дээр өгүүлсэн төрийн удирдлагын тогтолцооны төвлөрлийг сааруулах талаар гаргасан жишээнд үндэслэн гарц, үр дүн нь өөр хоорондоо хэрхэн уялддаг бөгөөд ямар ялгаатай болохыг доорхи диаграммд үзүүлээ.



Мониторингийн төслийн үе шат

Мониторинг нь эрдэм шинжилгээний чанартай судалгаа бус идэвхтэй оролцоо, оновчтой стратеги шаарддаг хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг бүхий цогц үйл ажиллагаа болох тухай өмнө дурдсан билээ. Нэг л бүрэлдэхүүн хэсэг нь орхигдвол үр дүнд хүрдэггүй. Үүнтэй холбоотойгоор мониторингийн төслийг хэрэгжүүлэхэд дор дурдсан үйл ажиллагааны үе шатыг дамжих бөгөөд мониторинг хийхээр сонгосон тодорхой сэдвийн онцлогоос шалтгаалан дараалал нь өөрчлөгдөж болно.



Мониторинг хийх асуудлыг сонгох

Мониторинг хийх асуудлыг сонгоход тухайн нөхцөл байдлын зөрчилтэй тал нь ил байх тохиолдол олон байдаг. Өөрөөр хэлбэл асуудал өөрийгөө томъёолоод өгөх нь бий. Тухайлбал, төрийн үйлчилгээний мониторинг хийхэд тухайн үйлчилгээ хариуцсан албан тушаалтнууд байнга гар хардаг, хүнд суртал гаргадаг тухай иргэд гомдоллодог жишээ байж болно. Энэ тохиолдолд тухайн

зөрчлийн талаар нотлох баримт мэдээлэл цуглуулан, үр дүнтэй нөлөөллийн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхэд анхаарлаа шууд хандуулах боломжтой.

Гэвч зарим тохиолдолд холбогдох этгээд хариуцлагаас мултрах зорилгоор аливаа зөрчилтэй асуудлыг санаатайгаар нуух, илрэхээс эмээн элдвээр далдлах нь бий бөгөөд ийм тохиолдолд тууштай эрэл хайгуул хийж баримт мэдээлэл олох шаардлага гарч ирнэ. Түүнээс гадна зарим үед нөхцөл байдал удаан хугацаанд давтагдсаар нэгэнт дадал зуршил болсон тохиолдолд олон нийтийн зүгээс тэр болгон тухайн асуудлыг сөхөн шүүмжлэх нь ховор байж болно.

Ийм тодорхойгүй нөхцөлд тухайн хөндсөн асуудалд мониторинг хийх шаардлагатай эсэхийг шийдэх үүднээс тандалт судалгаа хийж болно. Тандалт судалгааны үр дүнд уг асуудалд хамаатай нөхцөл байдлын талаар ерөнхий баримжаа олж авах бөгөөд түүнд үндэслэн мониторинг хийхдээ тодорхой таамаглал дэвшүүлэх боломжтой болно. Ингэснээр уг асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлахад ямар мэдээлэл шаардлагатай болох нь илэрхий харагдана.

Тандалт судалгаанд мэдээлэл харьцангуй хялбар аргаар олж авч болох эх сурвалжуудыг тогтоон тойм судалгаа хийх үйл ажиллагаа орно. Үүнд дараах аргуудыг ашиглаж болно.

- Экспертүүдтэй ярилцах (судлаач эрдэмтэд, хуулийн мэргэжилтнүүд, тухайн чиглэлээр ажилладаг ТББ-ын төлөөлөгч, холбогдох асуудлаар ажиллаж байсан буюу ажиллаж буй хувь хүмүүс гэх мэт)
- Мониторингийн асуудалд хамаатай, тухайн асуудлыг өөр өөр өнцгөөс харж тодорхойлох чадавхтай хүмүүсийг оролцуулан фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах (албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчид гэх мэт)
- Сонгосон асуудалтай холбогдох хууль эрх зүйн орчныг судлах (дотоодын болон олон улсын)
- Эрдэм шинжилгээний ажил, судалгааны тайлан дүгнэлтэнд анализ хийх
- Хэвлэл мэдээллээс авсан материалд урьдчилсан маягаар дүн шинжилгээ хийх, бичсэн сэтгүүлчтэй нь уулзаж ярилцах
- Иргэдээс холбогдох байгууллага хүмүүст ирүүлсэн гомдол саналд дүн шинжилгээ хийх
- Газар дээр нь очиж ажиглалт хийх

Тандалт судалгааны зорилго нь холбогдох асуудлыг гүн гүнзгий судлахдаа бус тухайн асуудалтай холбоотой тойм мэдээлэл олж авах явдал юм.

Тандалт судалгааны гол ач холбогдол нь мониторингийн сэдэв болгож сонгон авсан тухайн асуудлыг тодруулахад цаашид ямар мэдээлэл хэрэгтэй, юунд анхаарал хандуулбал зохих талаар баримжаатай болох явдал бөгөөд түүнд үндэслэн цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх боломжтой болдог.

Суурь судалгаа

Мониторингийн асуудлаа сонгосны дараа холбогдох баримт мэдээллийг цуглуулж эхлэхээс өмнө суурь судалгаа хийх нь мониторингийн хүрээнд гүйцэтгэх ажлыг оновчтой төлөвлөх, амжилттай хэрэгжүүлэхэд ач тустай. Суурь судалгааны хүрээнд дараах асуудлуудыг авч үзнэ:

- Эрх зүйн орчныг судлах

Мониторингийн сэдэвтэй холбоотой харилцааг зохицуулдаг эрх зүйн орчны талаар сайтар мэдлэгтэй байх нь төслийн үйл явцын амжилтад шууд хамаатай. Үүнд, Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенцээс эхлээд тухайн асуудалд холбогдох харилцааг зохицуулдаг бусад хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэр зэрэг бүх эрх зүйн акт орно.



Эдгээр хууль, дүрэм журам нь мониторинг хийхээр сонгосон уг асуудал ба бодит нөхцөл байдлыг харьцуулж үзэх стандарт буюу хуульчлагдсан хэм хэмжээ (норм) болно. Хэм хэмжээ нь уг асуудал ямар байх ёстойг заасан эрх зүйн баримт бичиг юм.

Хэрэв мониторинг хийхээр сонгосон асуудлыг зохицуулах эрх зүйн орчин хараахан бүрэлдээгүй байгаа бол тухайн асуудлыг зөв зүйтэй зохицуулдаг гадаад орны туршлага, олон улсын холбогдох баримт бичгүүдийг судалж үзэж болно.

Түүнчлэн зарим тохиолдолд мониторингт хамаатай нийгмийн харилцааг зохицуулж буй дотоодын хууль дүрэм дутагдалтай байж болох тул тэрхүү хуулийн цоорхой нь гажуудал үүсэх шалтгаан болж байж болзошгүй. Энэ тохиолдолд мөн гадаад орны оновчтой туршлага, олон улсын холбогдох баримт бичгийг судалж үзэх нь ач холбогдолтой учраас цаашид мониторингийн дүгнэлтэд үндэслэн нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд хамаарах хууль, дүрэм, журамд өөрчлөлт оруулах талаар санал зөвлөмж боловсруулан, хэрэгжүүлэх талаар санаачилга гаргаж болно.

- Мониторингт холбогдох байгууллагуудыг судалж тогтоох

Эдгээр байгууллагууд нь мониторингийн объект болох учир нарийн судалж тогтоох нь чухал.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Жишээ:

Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан /ЛЭОС/ ТББ-с 2006 онд алслагдсан хөдөө аймаг сумдад сурагчдын сурах бичгийн хангалтын байдалд мониторинг хийж, сурах бичгийг түгээх явцад гарч буй алдаа гажуудлыг засах боломж, бололцоог судлах зорилготой “Сурах бичиг” нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчны судалгаанд дараах хууль, эрх зүйн актуудыг авч үзжээ.

1. Бага, дунд боловсролын тухай хууль
2. 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн “Бага дунд боловсролын тухай хуудьд нэмэлт өөрчлөлт оруулах” тухай хууль
3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2005 он
4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
5. Журам шинэчлэн батлах тухай Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2006-03-29-ний өдрийн 108 дугаар тушаал
6. Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Сайд Сангийн сайд, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Сайдын Хамтарсан 2005-08-19-ний 251 дүгээр тушаал.
7. “Жагсаалт батлах тухай” БСШУ-ы сайдын 2006 оны 133 дугаар тушаал

Түүнчлэн мониторингт холбогдох байгууллагуудыг дараах байдлаар тогтоожээ:

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, мониторинг хийхээр сонгон авсан аймгийн Боловсрол соёлын газар, Ерөнхий боловсролын сургуулиуд, сурах бичиг үйлдвэрлэгч хэвлэлийн компаниуд.

- Мониторингийн сэдэвтэй холбоотой дүрэм журам, үйл явцын талаар мэдээлэл авах

Үйл явцын талаар дүрэм журам, нарийн шат дарааллыг мэдсэнээр хаана нь зөрчлийн голомт оршиж буйг ажиглан илрүүлэх, тэр талаар баримт мэдээлэл цуглуулах боломжтой болно.

Жишээ:

Дээр дурдсан ЛЭОС-ийн гүйцэтгэсэн “Сурах бичиг” мониторингийн төслөөс авсан жишээнд сэдэвтэй холбоотой үйл явцыг дараах байдлаар судалжээ.



- Мэдээлэл олж авах эх сурвалжаа тодорхойлох
 - Хүчин төгөлдөр хууль эрх зүйн баримт бичиг
 - Албан ёсны тайлан/ баримт бичгүүд
 - Мэргэжлийн ном зохиол болон өмнө хийгдсэн судалгаа
 - Хэвлэл мэдээлэл
 - Холбогдох хувь хүмүүс, албан тушаалтнууд, экспертүүд
 - Ажиглалт
 - Бусад

- **Ашиг сонирхлоороо хамаатай оролцогч талуудыг тодорхойлох**

Мониторингийн үйл ажиллагааг төлөвлөх явцад холбогдох хүмүүсийн санал бодлыг боломжийн хэрээр сонсох нь төлөвлөгөө оновчтой боловсруулахад тустай байдаг. Боломжийн хэрээр гэдгийн учир нь, тухайлбал авилгатай холбоотой асуудалд мониторинг хийх тохиолдолд авилга авсан этгээдүүд мониторингийн үйл ажиллагааг дэмжих, зөвлөх магадлал бага нь мэдээж юм. Гэвч тухайн салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан, өөр ажил эрхлэх болсон гэх зэрэг мэдээлэл өгөх, санал бодлоо эмээж цааргалалгүй хуваалцах хүмүүсийг оролцуулах нь ач холбогдолтой байдаг.

Жишээ:

“Сурах бичиг” мониторингийн төслийн хүрээнд ЛЭОС-ийн төслийн баг нь мэдээллийн эх сурвалж болон оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлжээ:

Мэдээллийн эх сурвалж: Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам / БСШУЯ/-наас гаргасан статистик үзүүлэлтүүд, сурах бичигтэй холбоотой гарсан тогтоол шийдвэр, мониторингд хамрагдсан аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын багш, нийгмийн ажилтан, номын санч, захирал, боловсрол соёлын газрын дарга, хэвлэлийн компаний гэрээт борлуулагч, сурагч, эцэг эхийн төлөөлөл.

Оролцогч талууд: Боловсрол Соёл Шинжлэх Ухааны сайд, БСШУЯ-ны сурах бичиг хариуцсан мэрэгжилтэн, хэвлэлийн компаний удирдлагууд, ерөнхий боловсролын сургуулиудын багш нар, нийгмийн ажилтнууд, номын санчид, захирал, боловсрол соёлын газрын дарга нар, хэвлэлийн компаний гэрээт борлуулагчид, сурагчид, эцэг эх.

Мониторингийн аргачлал

Мониторингийн үйл ажиллагааны амин сүнс нь баталгаатай, баримтжуулсан мэдээлэл мөн бөгөөд мэдээ баримтыг хэрхэн олж авахтай холбоотой нэн чухал асуудал нь аргачлал юм. Мониторингийн төслийн амжилт нь аргачлалыг хэрхэн зөв сонгож хэрэгжүүлэхтэй шууд холбоотой гэж үзвэл энэ асуудлын ач холбогдол тодорхой харагдана.

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг системтэй явуулах нь чухал. Төслийн зорилготой уялдаа багатай, замбараагүй цуглуулсан мэдээллийг багцалж, жинтэй дүгнэлт гаргахад хүндрэлтэй байдаг.

Мэдээлэл цуглуулахад судлаачид ихэвчлэн чанарын болон тоон гэсэн хоёр аргыг хослуулан хэрэглэдэг.

Чанарын судалгааны арга нь уян хатан бөгөөд асуудлыг олон талаас нь ухаж тайлбарласан шинжтэй байдаг. Чанарын судалгаанд яагаад, яаж, хэрхэн гэсэн асуултауд гол бөгөөд хүүрнэсэн бичмэл хэлбэрээр үр дүнг тэмдэглэнэ.

Тоон арга нь судалгааны объектын хэмжээ, тархалт, харьцаа хамаарлыг тодорхой түвшинд тоон хэлбэрээр илэрхийлсэн үзүүлэлтүүд юм.



Аливаа судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан хэрэглэх нь ач холбогдолтой байдаг.

Мэдээллийг олж авах байдлаар нь *анхдагч, хоёрдогч* мэдээлэл гэж ялгана.

Анхдагч мэдээлэл нь холбогдох хүмүүс, албан байгууллага, үйл явцаас шууд олж авсан мэдээлэл юм.

Хоёрдогч мэдээлэл гэж өөр бусад байгууллага буюу хүмүүс өмнө нь тодорхой зорилгоор цуглуулж хуримтлуулсан бэлэн мэдээллийг хэлнэ.

Мониторингийн онцлог нь оновчтой аргачлал, стратеги ашиглан нөхцөл байдлын талаар анхдагч “оригиналь” мэдээлэл, тодорхой кейс /бодит жишээ/ олж авахад оршдог. Тийм учраас мониторингийн ажлын цөм нь анхдагч мэдээлэлд үндэслэдэг гэж хэлж болно. Эндээс хоёрдогч мэдээллийн ач холбогдол тэгвэл юу вэ гэсэн асуулт аяндаа гарч ирнэ.

Хоёрдогч мэдээллийн эх сурвалжийг олж тогтоох нь төслийн үйл ажиллагааны эхэнд тухайн сонгосон асуудалд хэрхэн хандах, цаашид юу хийх талаар төлөвлөгөө боловсруулахад тус болдог. Энэ утгаараа хоёрдогч мэдээлэл нь төслийн явцад анхдагч мэдээллийг баяжуулан баталгаажуулж өгдөг ач холбогдолтой. Тухайлбал, таны төслийн онцлогоос хамааран статистикийн тоо баримт дурдах, архив, номын сангийн материал ашиглах, өмнө хийгдсэн судалгааны тайлангаас зарим хэрэгтэй мэдээлэл авах гэх мэт шаардлага гарч болно.

Мониторингт анхдагч мэдээлэл гол бөгөөд ийм мэдээллийг цуглуулахад нийгмийн судалгааны түгээмэл аргуудыг төслийн онцлогт тохируулан ашиглана. Иймд төслийн баг энэ талын мэдлэг, чадавхи эзэмшсэн байх нь чухал.

Нийгмийн судалгааны үндсэн ойлголтуудыг жагсаавал (Хүснэгт 1):

Судалгааны хөтөлбөр	Судалгааны үндэслэл, зорилго, зорилт, арга, аргачлал, төсөв, зардал, хүний нөөц, ажлын зохион байгуулалт, график төлөвлөгөө зэргийг багтаасан баримт бичиг
Судалгааны түүвэр	Судалгааны объектыг төлөөлж чадахуйц бүтэц, хэмжээтэй респондентүүдийн олонлогийг сонгох арга
Асуулгын арга	Анкетын болон сурвалжлагын аргаар мэдээлэл цуглуулах арга
Ажиглалтын арга	Стандарчилагдсан болон судлаачдын хувийн ажиглалтаар харьцуулсан нэмэлт мэдээлэл цуглуулах арга
Бичиг баримтын судалгааны арга	Сэдэвт холбогдох хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаа, онолын болон эмпирик судалгааны материалууд, бусад мэдээлэлд чанарын судалгааны аргын тусламжтайгаар шинжилгээ хийх
Судалгааны анкет	Асуулгын аргаар мэдээлэл цуглуулах зорилгоор тусгайлан боловсруулсан асуултууд
Судалгааны бусад хэрэглэгдэхүүн	Судалгааны явцад шаардлагатай нэмэлт хэрэглэгдэхүүнүүд, тухайлбал түүврийн хяналтын хүснэгт, гарын авлага г.м.
Судалгааны бэлтгэл үе	Мэдээлэл цуглуулахаас өмнөх хөтөлбөр, анкет хэрэглэгдэхүүн зохиох, шалгах, хэвлэх, хуваарилах үе
Судалгааны мэдээлэл цуглуулах үе	Асуулга, ажиглалт, бүлгийн ярилцлага, баримт бичгийн аргын тусламжтайгаар судалгааны зорилгын дагуу холбогдох мэдээллийг цуглуулах үе
Судалгааны мэдээлэл боловсруулах үе	Дээр дурьдсан судалгааны аргуудын тусламжтайгаар цуглуулсан мэдээллүүдэд шинжилгээ хийх
Судалгааны үр дүнг нэгтгэх үе	Тоон болон чанарын мэдээллүүдийг нэгтгэн эцсийн үр дүнг гаргах
Судалгааны тайлан бичих үе	Судалгааны мэдээллийг эцэслэн боловсруулж, үр дүн, санал зөвлөмжийг нэгтгэн илэрхийлсэн баримт бичиг гаргах
Тоон мэдээлэл	Шинж тэмдгийн утгуудыг нь тоогоор орлуулан тэмдэглэж болох, тоон хувиар илэрхийлэгдэх мэдээлэл

Тоон мэдээллийн шинжилгээ	Нийгмийн шинж тэмдгийн утгуудыг тоон хэлбэрт шилжүүлэн математик, статистикийн дүн шинжилгээ хийх
Чанарын мэдээлэл	Тоон утгаар илэрхийлэгддэггүй мэдээлэл
Чанарын дүн шинжилгээ	Тоон утгаар илэрхийлэх боломжгүй мэдээлэлд логик, бүтэц, үүргийн, шалтгаан үр дагаврын шинжилгээ хийх
Судалгааны объект	Судалж буй асуудлыг өөртөө багтаасан нийгмийн үзэгдэл, үйл явц, харилцаа, тал шинж
Респондент	Судалгаанд оролцуулахаар сонгож авсан, мэдээлэл өгч буй хүн
Субъектын нөлөө	Асуулгын явцад респондентын хариултад судлаачийн зүгээс нөлөөлөл үзүүлэх
Модератор	Фокус бүлгийн ярилцлагыг хөтлөгч
Фокус бүлэг	Нарийвчилсан судалгааны сэдвээр мэдээлэл цуглуулахад чиглэсэн албан ёсны бус энгийн хэлбэрээр ярилцлага өрнүүлж буй цөөн тооны хүмүүсийн бүлгийг хэлнэ. Судалгааны зорилго, хамрах хүрээтэй уялдан хүмүүсийн тоог харилцан адилгүй тогтоодог/дээд тал нь 12 хүн/.
Контент анализ	Бичиг баримтад, тэр дундаа хэвлэлийн материалыг судлах, шинжилгээ хийх социологийн арга

Анхдагч мэдээлэл цуглуулах аргууд

Мониторингт баттай баримт буюу факт цуглуулах нь гол ажил байдаг тул доор дурдсан аргуудыг ашиглан мэдээлэл олж авахдаа тодорхой асуудал, нөхцөл байдлын талаар бодит жишээ баримтад анхаарлаа хандуулах нь чухал юм. Энэ онцлогоос шалтгаалан дараах аргуудаас зарим нь баримт цуглуулахад илүү дөхөм, зарим аргууд ерөнхий тойм мэдээлэл олж авахад ашиглахад илүү зохимжтойг анхаарна уу! Тухайлбал; ганцаарчилсан ярилцлага, ажиглалт, туршилт, баримт бичиг судлах аргуудыг баримт кейс цуглуулахад голлон ашигладаг бол, анкет, бүлгийн болон фокус бүлгийн ярилцлага гэх мэт аргуудыг мониторингт нэмэлт ерөнхий мэдээлэл олж авах, судалж буй асуудлын талаар хүмүүсийн хандлагыг олж тогтооход ашиглана.

1. Ярилцлагын арга

Судлаач нь судалгаанд оролцогчтой ярилцах замаар үзэл бодол, хүсэл эрмэлзэл зэрэг сэтгэл зүйн дотоод ертөнцөд нь нэвтэрч, нийгмийн үзэгдэл, үйл явцын тухай шинэ сэргэг тоо, баримт мэдээлэл олж авдаг. Үүнийхээ үр дүнд уг үзэгдэл, үйл явцын тухай судалгаанд оролцогчийн санал бодол, үнэлэлт дүгнэлтийг танин мэддэг. Асуултыг амаар тавих бөгөөд судалгаанд оролцогч өөрийнхөөрөө хариулах, судлаач тухайн нөхцөлд тохируулан асуух, нэмэлт мэдээлэл авах боломжтой ч энэ арга нь цаг хугацаа, зардал, хүн хүч их зарцуулдгаараа дутагдалтай юм.

Ярилцлагын буюу сурвалжлагын арга нь:

- Ганцаарчилсан /ганц хүнтэй шууд ярилцах/
- Бүлгийн /олон хүний дунд явуулах/
- Телефон утасны /утсаар ярилцах/
- Шууд объектод очин үйл явцыг сурвалжлах

гэсэн хэлбэрүүдтэй байх бөгөөд чөлөөт ба чөлөөт бус байдлаар зохион байгуулна.

Чөлөөт бус ярилцлага гэдэг нь судлаач урьдчилан бэлдсэн асуултуудад тодорхой дарааллын дагуу хариулт авах хэлбэрийг хэлнэ. Энэ нь олон тооны хүмүүсээс ярилцлага авах шаардлагатай эсвэл судлаач өөрөө тухайн асуудал, нөхцөл байдлын талаар харьцангуй гүнзгий мэдлэгтэй бол тохиромжтой.

Шалган судалж байгаа асуудал, нөхцөл байдлын талаар судлаачид гүн гүнзгий мэдлэг дутмаг, эсвэл эмзэг сэдвийн талаар ярилцах тохиолдолд чөлөөт хэлбэрийн ярилцлага тохиромжтой. Чөлөөт хэлбэрийн ярилцлага нь респондентоос урьдчилан тогтсон асуултуудад тодорхой дэс дарааллын дагуу хариулт авалгүйгээр ярилцлагыг ерөнхийд нь залах сэдвүүдийг жагсаан бэлдэж, тэдгээрийн дагуу ярилцагчаас мэдээлэл авах журмаар явагддаг. Ярианы явцаас хамааран сэдвийнх нь дараалал ямар ч байж болдог.



Чөлөөт ярилцлагын явцад ажиглалт хийх, мэдээллийг орхигдуулалгүй тэмдэглэх нь чухал бөгөөд үүний тулд ярилцлагыг хоёр хүн хамтран авах нь дөхөмтэй байдаг. Ярилцагч цааргалахгүй бол дуу хураагуур ашиглаж болох бөгөөд ярилцлагыг дараа нь цаасан дээр буулгаж тэмдэглэнэ. Ярилцлага авч байгаа хүн ярилцагчийн асуултад хариулах байдалд нь санамсаргүй нөлөөлөх тохиолдол гардаг. Ийм үед ярилцагч ярилцлагын зорилгод үл итгэх, асуултыг булзааруулах, бөөрөнхийлсөн хариулт өгөх магадлалтай. Ийм байдлаас зайлсхийх үүднээс ярилцлагын зорилгыг ярилцагчид урьдчилан сайтар ойлгуулах нь тустай бөгөөд эмзэг асуудлыг аль болох энгийн зохистой байдлаар асуух, хангалттай цаг зарцуулах, шаардлагатай бол ярилцагчийн нэрийг нууцлахаа мэдэгдэх гэх мэт аргыг хэрэглэх нь зүйтэй.

Жишээ:

2005 онд шүүхийн мониторинг гүйцэтгэсэн Хүний эрх шударга ёсны холбооны мониторингийн багийн гишүүн Цогзаяабаатар:

Ярилцлагын арга нь хамгийн үр дүнтэй арга мөн. Харилцан ярианы явцад үнэнийг тодорхой хэмжээгээр сонсох боломжтой байдаг. Хүмүүс эхэндээ гол зүйлээ ярьдаггүй. Нэлээд лавшруулахаар гол юм нь гарч ирдэг. Түүн дундаас фактыг олох боломжтой байсан. Дутагдалтай тал нь их цаг зарцуулдаг.

2. Ажиглалтын арга

Ажиглалтын арга гэдэг нь хүмүүсийн хандлага, зан байдал, аливаа үйл ажиллагааны явцыг системтэй сонгож ажиглах, ажигласан зүйлээ тэмдэглэхийг хэлнэ. Энэ арга нь дараахь онцлогтой:

- Дэвшүүлсэн таамаглалыг нотлох эсвэл үгүйсгэх зорилготой;
- Зохион байгуулагдсан, системтэй;
- Өргөн хүрээтэй мэдээлэл шаардах;
- Үр дүн нь юмс үзэгдлийг үнэн зөв тусгасан;
- Үр дүн нь судлаачаас юмс үзэгдэлд бодитой хандахыг шаарддаг.

Ажиглалтыг гүйцэтгэх байдлаар нь **оролцооны** болон **хөндлөнгийн** гэж хоёр хуваана.

Оролцооны арга нь судлаач тухайн ажиглалтын объект болох үйл явцынхаа нэг хэсэг болон оролцох ба ингэж оролцох явцдаа санал бодлоо чөлөөтэй хуваалцахыг хэлнэ.

Хөндлөнгийн ажиглалт гэдэг нь судлаач асуулт асуух буюу үзэл бодлоо илэрхийлэн оролцохгүйгээр ил эсвэл далд маягаар ажиглалт хийх үйл явц юм.

Ажиглалт нь ил буюу холбогдох хүмүүст тэдний үйлдэл, зан байдал зэргийг ажиглаж байгаа талаараа мэдэгдэх, далд буюу өөрсдөд нь мэдэгдэлгүйгээр ажиглах хэлбэртэй байж болно.

Ярилцлага, санал асуулгын аргуудтай харьцуулбал ажиглалтын арга нь хүмүүсийн зан байдал, үйл явцын талаар баттай нарийн мэдээлэл олж авах боломж олгодог сайн талтайгаас гадна ярилцлагаас олж авсан мэдээллийн үнэн зөвийг батлах боломжтой.

Ажиглалтын аргыг мөн байшин барилга гэх мэт тодорхой объект дээр ашиглаж болно.

Ажиглалтаар олж авах мэдээллийг системтэй байлгах үүднээс судлаачид сонирхсон асуудлуудаа багтаасан нэг загварын ажиглалтын карт ашиглах нь зүйтэй. Ингэснээр хэд хэдэн ажиглагчийн цуглуулсан мэдээллийг харьцуулж нэгдсэн дүгнэлт гаргах боломжтой болно.

Жишээ:

“Тусламжийн Тэргэнцэр Сан”-гаас засаг захиргаа, олон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид тэргэнцэртэй иргэд нэвтэрч үйлчилгээ хүртэх боломж ямар байдалтай байгаад мониторинг хийхдээ хэд хэдэн барилга байгууламжид тэргэнцэрийн зам байгаа үгүйг, хэрэв байгаа бол зохих журмаараа баригдсан эсэхийг судлан ажиглах замаар баримт цуглуулжээ.

3. Туршилтын арга

Туршилт судалгааны аргыг ашиглахдаа мониторингийн объект болох үйлчилгээний байгууллагаар судлаачид өөрсдөө үйлчлүүлж оролцох замаар нөхцөл байдлын талаар бодит кейс бий болгоно.

Жишээ:

“Зориг сан”-гаас 2005 онд Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулагийн боомтын гаалийн албад болон Улаанбаатар хот дахь Толгойтын Гүнийн гаалийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийсэн. Мониторингийн багийнхан хилээр орох, гарах урсгалд ажиглалт хийхдээ Замын-Үүдийн хилийн боомтын гаалийн албаар үйлчлүүлж туршилтын аргыг хэрэглэсэн байна. Мониторингийн багийн гишүүн Галцогийн хэлснээр: “Бид эхлээд байгууллагын удирдлагуудад нь хандахгүй гэж үзсэн. Замын-Үүд явахдаа энгийн иргэн болсон. Тэгээд Эрээнд очиж хүний бараа гаргадаг хүн болж гааль дээр барааг нь гаргаад нөгөөд нь өгөөд явсан. Өөрөөр хэлбэл, авилгал өгсөн хүн болж байгаа юм. Дараа нь Алтанбулагт очихдоо дарга нарт нь бичиг хүргүүлж урьдчилан мэдэгдчихээд очсон. Гэтэл Ялалтынхаа талбайд биднийг их өндөр түвшинд хүлээж авсан. Тэгэхээр эхнийх нь бидний судалсан сэдвийн хувьд нэлээн үр дүнтэй арга болох нь харагдсан.

4. Баримт бичиг судлах арга

Үүнд гараар бичсэн болон хэвлэмэл бичиг, гэрэл зураг, соронзон бичлэг, кино хальсанд бичигдэж тэмдэглэсэн янз бүрийн мэдээллүүдийг оруулдаг бөгөөд эдгээрийг судалж шинжлэх нь нөхцөл байдлыг олон талаас нь цэгцтэй судлах боломж олгодог.

Мониторинг хийхэд дараах баримт бичгүүдийг судалж үзэж болно:

- Эрх зүйн баримт бичиг: дээр өгүүлсэнчлэн мониторингийн асуудалд хамаарах эрх зүйн баримт бичиг судлах нь мониторингийн ажлын чухал хэсэг бөгөөд үүнд доод шатны байгууллагуудын гаргаж баталсан дүрэм журам бас орно.
- Байгууллагын дотоод баримт бичиг (санхүүгийн данс тооцоо, бусад баримт бичиг, иргэдийн өргөдөл, санал гомдол хүлээж авсан бүртгэл гэх мэт)
- Байгууллагаас гаргасан бусад баримт бичгүүд (шүүхийн тушаал, шийдвэр, байгууллагын удирдлагын шийдвэр, тайлан, эрхлэн гүйцэтгэсэн экспертийн судалгааны тайлан, аудитын дүгнэлт тайлан гэх мэт)
- Байгууллагаас иргэдтэй харилцсан захидал харилцаа
- Иргэдээс төрийн байгууллагуудад илгээсэн өргөдөл гомдол
- Мэдээ, статистик тоо баримт (Яамдын гаргасан тайлан, судалгааны тайлан гэх мэт)
- Хэвлэл мэдээлэл, интернэтийн мэдээлэл
- Бусад баримт бичгүүд (байгууллагуудын мэдээллийн самбарт тавигдсан мэдээлэл гэх мэт)



Норматив баримт бичгээс бусад баримт бичигт судалгаа хийхэд тэдгээрт байгаа мэдээллийн үнэн зөв эсэх талаар асуулт аяндаа тавигдана. Судалж үзэж буй баримт бичиг бүрийг байнга шүүмжлэлтэй нүдээр харж, бусад эх сурвалжаас авсан мэдээллээр баталгаажуулж байх нь чухал. Боломжтой үед баримт бичиг дээрх мэдээллийг бодит байдалтай харьцуулж үзэх нь зүйтэй.

Жишээ:

“Нийгмийн Халамж Хамтын Ажиллагааны Сан”-гаас 2005 онд Баянхонгор, Дорнод аймгуудын ахмад настнуудын асрамжийн газруудын үйлчилгээнд мониторинг хийхэд санхүүгийн баримтад дүн шинжилгээ хийх шаардлага гарсан. Тэдгээр баримт бичигт үзүүлсэн тоог тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай харьцуулах замаар болон асруулагчдаас ярилцлага аван баталгаажуулахад зөрүүтэй зүйлс их гарсан нь асрамжлуулагчдад зориулан зарцуулах ёстой хөрөнгө мөнгөний зарим нь хүрэх ёстой эзэддээ очдоггүй гэсэн дүгнэлтэд хүргэжээ.

Баримтыг чанарын ба тоон анализын аргаар шинжилнэ.

Чанарын арга нь баримт бичгийн агуулга дахь нуугдмал далд шинж чанарыг илрүүлэхэд чиглэгдэх ба түүний үндсэн агуулгыг бүрэн нээж логик үндэслэлийг илрүүлнэ. Баримт бичгийг ийнхүү шинжлэхэд дараах шалгуур асуултуудыг ашиглах боломжтой:

- Юуны тухай бичиг баримт болох
- Эх бичгээр байгаа эсэх
- Зохиогч буюу бүтээгч нь ямар хүн бэ
- Ямар зорилгоор бүтээгдсэн
- Үнэн магадтай эсэх
- Нийгмийн ямар үзэгдэл, үйл явцыг тусгасан болох
- Агуулгад нь үнэлгээний асуудал хэр туссан болох
- Агуулга дахь тоон баримтуудад ямар дүгнэлт хийх боломжтой вэ
- Үнэлгээний асуудалд ямар дүгнэлт хийх вэ
- Бичиг баримт бүтээгчид /зохиогчид/ ямар үнэлэлт өгөх вэ гэх мэт.

5. Фокус бүлгийн ярилцлагын арга



Төслийн онцлогоос шалтгаалан боловсрол, сонирхол, итгэл үнэмшил, нас, мэргэжил, туршлага гэх мэтээрээ ижил төстэй хүмүүсийг нэг дор цуглуулан тодорхой сэдвийн дагуу ярилцлага зохион байгуулахыг фокус бүлгийн ярилцлага гэнэ. Фокус бүлгийн ярилцлагын онцлог тал нь оролцогчдын хоорондын ярианд судлаач зөвхөн чиглүүлэх төдий үүрэгтэй оролцон голдуу хөндлөнгөөс ажиглах бөгөөд тэдгээр хүмүүст аливаа асуудлын талаар илэн далангүй ярилцах, санал нийлэх, зөрөлдөх боломж олгох замаар тухайн сэдвийн талаар аль болох олон талт мэдээлэл олж авдаг явдал юм.

Фокус бүлгийн ярилцлагыг энгийн бүлгийн ярилцлагаас ялгаж ойлгох нь чухал. Энгийн бүлгийн ярилцлагын үед судлаачийн тавьсан асуултад хүмүүс ээлжлэн хариулдаг бол фокус бүлгийн ярилцлага нь оролцогчид өөр хоорондоо ярилцах замаар явагдана. Фокус бүлгийн ярилцлагад хамгийн цөөн нь 6, хамгийн олондоо 12 хүн урьж оролцуулбал зохистой гэж үздэг.

Фокус бүлгийн ярилцлагын зорилго нь тодорхой асуудлын талаар хүмүүсийн хандлага, үзэл бодолтой холбоотой ерөнхий тойм мэдээлэл олж авах явдал байдаг. Иймд фокус бүлгийн ярилцлагыг төслийн эхэнд зохион байгуулах нь төслийн цаашдын үйл явц, авч хэрэгжүүлэх арга хэмжээг шийдэж тодорхойлоход ач холбогдолтой байдаг.

Фокус бүлгийн ярилцлагыг 3-аас доошгүй судлаач зохион явуулна. Судлаач бүр өөр өөр үүрэгтэйгээр оролцоно.

Ярилцлага хөтлөгчийн үүрэг: Фокус бүлгийн ярилцлагыг удирдан явуулж буй судлаачийг хэлнэ.

- Бүлгийн ярилцлагад оролцогчдын дотор хялбархан орж, итгэлийг нь төрүүлэх
- Ярилцаж буй сэдвээр энгийн ойлгомжтой ярилцах
- Оролцогчдын гаргасан санааг ойлгож, ярилцлагыг зөв чиглүүлэхийн тулд эртнээс судалгааны сэдэвтэй танилцсан байх. Түүнтэй холбоотой нэмэлт мэдээллүүдийг авсан байх ёстой.

- Ярилцлага хөтлөгч уян хатан, сайн сонсож чаддаг байхын зэрэгцээ, бүх санааг анхааран авч үзэхийг хичээнэ.
- Ярилцлагыг хөтлөгч нь судалгааны асуудлын хүрээнд оролцогчтой ярилцахаар бэлтгэсэн тодорхой сэдэв, удирдамжийг ашиглана.
- Өөрийн зүгээс санаа юм уу, мэдээлэл өгөх ёсгүй.
- Тодотгох асуултуудыг /хэр олон, хичнээн, яагаад, яаж хэрхэн г.м./ өргөн ашиглаж, ярилцагчдыг өдөөн, ярилцлагыг өрнүүлэх хэрэгтэй.
- Ярилцлага хөтлөгч судалгааны зорилго буюу тухайн бүлгээс юу олж мэдэхийг хүсэж байгаагаа мартажгүй байх нь чухал.
- Ярилцлага хөтлөгч нь ичимхий бүрэг хүмүүсийг ярианд татан оруулж, илэн далангүй байх уур амьсгалыг бүрдүүлэх хэрэгтэй.
- Янз бүрийн санаа бодлыг сонсох сонирхолтой байгаагаа илэрхийлнэ.



Тэмдэглэл хөтлөгчийн үүрэг:

- Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээллийг судалгааны танилцах шатанд нэг бүрчлэн тэмдэглэж авна.
- Ярилцлагын тэмдэглэлийг тусгай хуудсанд бичнэ.
- Оролцогчдоос хэн нь юу хэлж байгааг, ишлэлийн хамт нямбай тэмдэглэнэ.
- Судалгаатай холбоотой нийтлэг буюу ялгаатай байр суурийг илрүүлж гаргана.
- Тэмдэглэл хөтлөгч ерөнхий удирдамжийг нэг бүрчлэн уншиж танилцан, үг үсэг, нэр томъёоллыг нягталж шалгах ёстой.
- Ярилцлагын тэмдэглэгээг бичих явцад зарим дүгнэлтийг тодотгож хийнэ. Тухайлбал, бүгд хүлээн зөвшөөрч буй асуудал, хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч буй асуудал, хүмүүсийн хамгийн идэвхтэй сонирхон хариулсан асуулт г.м.

Ажиглагчийн үүрэг:

- Ярилцлагын явц, зохион байгуулалтад хяналт тавин оролцоно.
- Ажигч гярхай байна.
- Оролцогчдоос янз бүрийн асуултанд хэрхэн хариу өгч, гадаад төрх, үйл хөдлөл нь хэрхэн өөрчлөгдөж байгааг анхааралтай харж тухай бүр нь тэмдэглэж авна.
- Ярилцлага хөтлөгчийн ажлыг давхар хянан, алдаатай болон орхигдсон санааг оролцогчдод мэдэгдэхгүйгээр түүнд бичгээр мэдэгдэнэ.
- Зураг авах, дуу хураах зэрэг ажлыг хариуцна.
- Бүлгийн ярилцлагад саад учруулж болзошгүй зүйлүүдээс урьдчилан сэргийлнэ.
- Тэмдэглэл хөтлөгчийн ажилд тусална.



Фокус бүлгийн ярилцлагын үе шат

Бэлтгэл үе:

- Оролцогчдыг заасан удирдамжийн дагуу сонгоно.
- Аль болох дуу чимээ багатай, цахилгаан ашиглах боломжтой, суудлын тоо хангалттай байрыг сонгон бэлтгэнэ.
- Тухайн байр нь оролцогчдод хүртээмжтэй байхаас гадна 2 цагийн турш таны мэдэлд байх нь чухал.
- Оролцогчдод зориулж цай гэх мэт зүйлсийг бэлдэнэ.
- Судалгааны хэрэглэгдэхүүнийг бэлдэнэ. / удирдамж, дуу хураагуур, зургийн аппарат г.м./
- Ярилцлагын байрыг бэлдэхдээ хөтлөгч болон оролцогчид шууд харилцах боломжтой, тойрсон байдлаар буюу хөтлөгч оролцогчдод бүгдэд хяналт тавих, яриа сонсогдох боломжтой байдлыг харгалзана.

Танилцах үе: /10 орчим минут/

- Хөтлөгч нь судлаачдын багийн бүрэлдэхүүн, судалгааны зорилго, зохион байгуулалт зэргийг танилцуулна.
- Мөн ярилцлагад оролцогчдыг өөрсдийгөө танилцуулахыг хүсэх хэрэгтэй.
- Танилцах асуултыг маш сонирхол татахуйцаар асуу.
- Ярилцлагыг дуу хураагуурт болон, тэмдэглэл байдлаар бичиж байгаа гэдгийг хэлэх, болгоомжлох хэрэггүй гэдгийг сануулна.

Итгэлцэл бий болгох үе: /10 орчим минут, 1-2 асуулт/

- Ярилцлага хөтлөгч нь хариулахад маш энгийн, хялбар асуултуудыг асуун, оролцогчдыг ярилцлагад татан оролцуулна.
- Эдгээр асуултууд нь ерөнхий судалгааны чиглэлтэй боловч маш энгийн амархан байх ёстой.
- Асуултуудын зорилго нь оролцогчдод таатай сэтгэгдэл төрүүлэх, ярихад нь чөлөөтэй, ямар нэгэн дарамтгүй орчинг бүрдүүлэхэд чиглэнэ.

Гүнзгийрүүлэх үе шат: /60 орчим минут/

- Ярилцлага хөтлөгч ярилцлагыг сэдвийн удирдамжийн гол асуултуудад чиглүүлнэ.
- Яриа өдөөн, дэмжиж, судлагдаж буй зүйлийн нөлөөллийг болон оролцогчдын санаа бодлыг илрүүлнэ.
- Ярилцлага хөтлөгч асуулт бүрт бүтээлчээр хандаж, энэ нь судалгаанд чухал болохыг оролцогчдод ойлгуулж, тэдний хандлага, байр суурь, амьдралын туршлагыг нээх, илрүүлэхийг хичээнэ.
- Ярилцлага хөтлөгч нь оролцогчидтой хамтран ярилцаж, яриаг чиглүүлэн хөтлөх боловч, ярилцлагыг удирдан хошуучилж болохгүй. Энэ үе шат 60 орчим минут үргэлжилнэ.

Хаах үе шат: /10 орчим минут- нэгтгэн дүгнэх, хүсэлт, талархал/

- Ярилцлага хөтлөгч ярилцлагын явцад гарсан, зөвшөөрсөн, үл зөвшөөрсөн

- асуудлуудын талаар санаа бодол, зөвлөмжийг нэгтгэн танилцуулна.
- Тэдгээрийг тодорхойлох, бататгах, сайжруулах талаар оролцогчид асууж болно.
- Энэ үе шатанд ярилцлага хөтлөгч илүү их ярих хэрэгтэй.

6. Асуулгын арга

Нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцын талаар хүмүүсийн санал бодол, хүсэл, сонирхол, амьдрал, үйл ажиллагааны сэдэл, шалтгаан, үр дүнгийн тухай үнэлэлт, дүгнэлт авах, энэ талын мэдээлэл цуглуулахад асуулгыг ашигладаг.



Асуулгын аргыг мониторингт нэмэлт мэдээллээр асуудлаа баяжуулахад ашиглах бөгөөд хэзээ ч дангаар нь үндсэн буюу гол арга болгон хэрэглэдэггүй.

Асуулгын аргад анкетын ба сурвалжлагын аргууд орно.

Анкетын арга нь:

- Экспертийн /тухайн объектын талаар илүү мэдлэгтэй хүмүүсээс авах/
- Ганцаарчилсан /судалгаанд оролцогчийн хувийн онцлогт тулгуурласан/
- Шуудангийн /шуудангийн хайрцгаар дамжуулж авах/
- Хэвлэлийн /сонин, сэтгүүлд хэвлэх байдлаар мэдээлэл авах/
- Сурвалжлагын /сурвалжлагын асуултуудыг бичгээр илэрхийлнэ/
- Тестийн / мэдлэг, чадвар шалгах шалгалтын тест/
- Санал асуулгын /тодорхой сэдвээр бэлтгэсэн/

Анкетын арга нь бичгээр илэрхийлдэг, боловсруулахад хялбар, хүн хүч, хугацаа, зардал хэмнэх боломжтой ч нэг хэвэнд хэт орох, судлаачийн зааж өгсөн хувилбарт хариултуудаас л сонгох боломжтой байдгаараа дутагдалтай юм.

Анкет гэдэг нь судлах зүйл, судалгааны зорилгоос хамааран нийгмийн үзэгдэл, үйл явцын тоо, чанар, шалтгаан, үр дагаврын учир холбогдол, онцлогийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн тодорхой агуулга, бүтэц, зохион байгуулалт, дарааллаар урьдчилан бэлтгэж, хэвлэсэн асуулт, хариултын цогц юм.

Анкетыг ерөнхийд нь гурван хэсгээс бүрдэнэ гэж үздэг бөгөөд

- Эхний хэсэгт /судалгааны зорилго, зохион байгуулалттай холбоотой тайлбар, судалгаанд оролцогчийн хүн ам зүйн шинжүүдийг тодорхойлох асуултууд, гол зорилгод хандан, чиглүүлсэн хөнгөн асуултууд орно/
- Дунд хэсэгт /гол зорилготой холбоотой асуултууд орно/
- Төгсгөл хэсэгт хөнгөн, сонирхолтой, шууд хариулах боломжтой асуултууд орно.
- Судалгааны эцэст нь талархал илэрхийлнэ.
- Асуултыг дотор нь:
- Нээлттэй /хариултын хувилбарыг зааж өгөөгүй/ ба хаалттай /бүх хариултыг хамтад нь өгсөн/

- Ил ба далд утгатай
- Хамаатуулсан ба тойруулсан
- Үндсэн ба үндсэн бус
- Ганц ба олон сонголттой
- Нэрлэсэн /хариултын хувилбаруудыг тоочсон/, эрэмбийн /үнэлгээний хэлбэртэй хариулттай/, интервал /тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэх/ гэж ангилна.



Асуулгын судалгааг тодорхой асуудлаар хүмүүсийн бодол санааг олж мэдэх зорилгоор хийж болно. Жишээ нь: Ямар байгууллагыг та хамгийн их авилгад өртсөн гэж боддог вэ? Гэвч ийм төрлийн асуулгын хариу зөвхөн судалгаанд оролцогчдын санааг илэрхийлж буй учир баттай баримт гэхэд бэрх бөгөөд үүнд болгоомжтой хандах нь чухал юм. Хүмүүсийн туршлагын талаар сурвалжилсан асуулга нь илүү нарийн баримт олж чаддаг. Жишээ нь: Төрийн албан тушаалтан танаас авилга өгөхийг шаардсан тохиолдол гарч байв уу?

Анхдагч мэдээлэл цуглуулах арга хэлбэрүүдийн сул болон давуу талууд



Дээр дурдсан аргууд бүгд тус бүрдээ сул болон давуу талтай. Та өөрийн төслийн онцлогт тохируулан хэд хэдэн аргыг хослуулах нь хамгийн үр дүнтэй.

Анхдагч мэдээлэл цуглуулах арга, хэлбэрүүдийн сул болон давуу тал

Арга хэлбэр	Давуу тал	Сул тал
Ажиглалт	<p>Асуудал, нөхцөл байдлын талаар бодитой дэлгэрэнгүй мэдээлэл олж авах боломжтой</p> <p>Ярилцлагын үед мэдэгдээгүй баримт мэдээлэл олж болно</p> <p>Асуулгын хариултын үнэн зөвийг биеэр магадлах боломжтой</p>	<p>Мэдээллийн эх сурвалжийн нууцлалтай холбоотой ёс зүйн асуудал тулгарч магадгүй</p> <p>Ажиглагчийн субъектив хандлага нөлөөлж болзошгүй (зөвхөн өөрийн сонирхсон зүйлээ олж харах г.м)</p> <p>Ажиглагч байгаа нь нөхцөл байдлыг ердийн байдлаас өөрөөр харагдуулах хүчин зүйл болох магадлалтай</p>

Арга хэлбэр	Давуу тал	Сул тал
Ярилцлага	<p>Бичиг үсэгт тайлагдсан болон тайлагдаагүйгээс нь үл хамааран хүмүүсийг тэгш хамруулж болно</p> <p>Ойлгомжгүй хариулт ирэх тохиолдолд тодруулах боломжтой</p> <p>Анкетын асуулгыг бодвол сонирхсон асуултдаа хариулт авах нь хялбар</p>	<p>Ярилцлага авагч ярилцагчийн хариулт өгөх байдалд нөлөөлөх магадлалтай</p> <p>Ажиглалттай харьцуулбал зарим мэдээлэл орхигдож болзошгүй</p>
Чөлөөт ярилцлага	<p>Нөхцөл байдлын талаар нарийн дэлгэрэнгүй мэдээлэл олж авах боломжтой</p> <p>Респондент санамсаргүй маягаар үнэтэй мэдээлэл өгөх нь бий</p>	<p>Ярилцлага авагч респондентын хариу өгөх байдалд анзааралгүй нөлөөлөх магадлалтай</p> <p>Ийм аргаар олж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх хэцүү, цаг их шаардагдах ажил байдаг</p>
Чөлөөт бус ярилцлага	<p>Дүн шинжилгээ хийхэд амархан</p>	<p>Респондент чөлөөтэй санал бодлоо илэрхийлэх боломж бага учир зарим чухал мэдээ баримт орхигдож болзошгүй</p>
Анкет асуулга	<p>Харьцангуй хямд төсөр өртөгтэй</p> <p>Респондент нүүр царай, нэр сэлтээ нууцлах боломжтой учир илүү үнэн зөв, шударга хариулт өгөх магадлал нь өндөр</p> <p>Ойлгомжгүй хариулт буй тохиолдолд тодруулах боломж бага</p>	<p>Бичиг үсэг мэдэхгүй хүмүүсийг хамруулах боломжгүй</p> <p>Хүмүүс хариу өгөх нь харьцангуй цөөн</p> <p>Зарим асуултуудыг буруу ойлгож магадгүй</p>

Арга хэлбэр	Давуу тал	Сул тал
Баримт бичиг	Мэдээлэл олж авах үнэ өртөг бага Өнгөрсөн үетэй харьцуулахад хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг судлах боломжтой	Байгууллагууд баримт мэдээлэл өгөхөөс цааргалах магадлалтай Мэдээллийн эх сурвалжийн нууцлалтай холбоотой ёс зүйн асуудал үүсэж болзошгүй
Фокус бүлгийн ярилцлага	Бүлгийн ярилцлагатай харьцуулахад хямд төсөр бөгөөд цаг бага шаардана Бичиг үсэг мэдэхгүй хүмүүс оролцох боломжтой Хариулт ойлгомжгүй тохиолдолд тодруулах боломжтой Оролцогчид санамсаргүй маягаар үнэтэй мэдээлэл өгөх нь бий	Үр дүнг олон нийтийн үзэл бодлын төлөөлөл болгон ашиглах боломжгүй Хүмүүс бие биенээ аялдан дагалдах байдал гардаг учир үр дүнг шинжлэхдээ болгоомжлох нь зүйтэй Туршлага муутай модератор оролцогчдын ярианд нөлөөлөх магадлалтай Хувь хүн тус бүрийн санааг лав тусгаж чаддаггүй



Мониторингийн мэдээлэл цуглуулахад асуулга, ажиглалт, бичиг баримт, туршилтын гэх мэт хэд хэдэн аргыг хамтатган ашиглах нь нөхцөл байдлын талаар илүү нарийн, олон талт мэдээлэл олж авах боломж олгодог. Хэд хэдэн аргыг ийнхүү хослуулснаар тухайн сонгосон аргын сул талыг нөхөх, давуу талыг бататгах нөхцөл бүрддэг.

Тухайлбал төрийн аль нэг үйлчилгээнд мониторинг хийж байгаа тохиолдолд тухайн үйлчилгээний талаар иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, хандлага, үнэлгээг анкетаар, кейс жишээг ганцаарчилсан ярилцлагаар, үйлчилгээний дүр байдлыг ажиглалтаар, үйлчилгээний хүндрэл, хүнд суртал, гажуудлын талаар баримт цуглуулах, нотлох зэрэгт туршилтын аргыг ашиглаж болно.

Мэдээллийг баримтжуулж баталгаажуулах

Мониторингийн мэдээлэл баталгаатай бөгөөд баримтад тулгуурласан байх нь төслийн амжилтад шууд хамаатай. Мониторингоор хөндсөн асуудал, түүнд холбогдох нөхцөл байдлыг сайжруулахад олон нийтийн болоод төрийн эрх мэдэлтэн, албан хаагчдын оролцоо дэмжлэгийг олж авах нь чухал учраас тэдний итгэл үнэмшил гол үүрэгтэй. Иймд тэдэнд танилцуулж буй мэдээллийн үнэн зөв байдал баталгаатай байх нь нэн чухал юм.

Мэдээ баримтын эх хувийг нэгдсэн дүн шинжилгээ хийж мониторингийн үйл ажиллагаа дуусаж, тайлан хэвлэгдсэнээс хойш ч устгаж, үрэгдүүлэлгүй найдвартай хадгалж хамгаалах нь зүйтэй.

*Хүний эрхийн мониторингийн гарын авлага
Хельсинкийн хүний эрхийн сан*

Дээрх шалтгаанаас үүдэн аливаа мэдээллийг анхдагч болон хоёрдогч хэд хэдэн эх сурвалжаас давхар судлан баталгаажуулахаас гадна мониторингийн мэдээлэл баримтжуулах үйл явцыг мэдээлэл олж хуримтлуулах ажиллагаатай хамт орхигдуулалгүй хийх хэрэгтэй. Мониторингийн тайланд дурдсан мэдээллийн эх хувийг архивлан хадгалах, мэдээлэл өгсөн хүмүүсийн аюулгүй байдал, нэр төр, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хөндлөнгийн этгээдийн гарт орохоос сэргийлэх арга хэмжээ авах нь чухал.

Мэдээллийг баримтжуулах дараах хэд хэдэн төрлийн арга хэлбэр байдаг.

А. Байгууллагын албан ёсны баримт бичгийг хуулбарлан хадгалах

Жишээ нь: мониторингт хамрагдсан албан байгууллагуудын дотоод баримт бичиг, гэрээ, маягт, албан тушаалтнуудын бичгээр гаргасан тушаал, заавар гэх мэт.

Б. Иргэд албан тушаалтнуудын харилцсан захиа, өргөдөл

Захидал, өргөдлийн эх хувь нь байгаа тохиолдолд алдагдах болон гэмтэхээс сэргийлэн болгоомжлох үүднээс хуулбарыг өөр газар хадгалах нь зүйтэй байдаг.

В. Мэдүүлэг, мэдэгдэл

Үүнд мониторингийн хүрээнд хөндсөн тодорхой асуудалтай холбоотой гэрч/ хохирогч/ экспертийн өгсөн мэдэгдэл, мэдүүлэг гэх мэт баримт орно.

Г. Аудио, видео бичлэг, зураг

Ярилцлагыг хуурцагт бичих, яриаг цаасан дээр буулгах, хэзээ хаана болсныг баримтжуулан тэмдэглэл хөтлөх, үйл явдлын зураг авах нь чухал нотлох баримт болдог.

Д. Биет баримт

Шаардлагатай үед мониторингийн баримтыг хуурамчаар үйлдсэн гэх болзошгүй зэмлэлээс сэргийлэхэд мэдээлэл өгсөн хүмүүсийн гарын үсэг бүхий баримт тустай байдаг. Ийм баримтад тухайн мэдээ баримтыг

- хэзээ олж цуглуулсан болох
- хаанаас олж цуглуулсан болох
- хэн олж цуглуулсан болох тухай мэдээлэл
- баримт мэдээлэл өгсөн хүний гарын үсэг зэрэг багтсан байна.




Орчин үеийн техник, технологийн ололттой холбоотой аливаа баримтыг электрон хэлбэрээр хадгалах нь элбэг болсон. Ийм хэлбэрээр байгаа баримт материалыг техникийн элдэв шалтгааны улмаас устаж үрэгдэхээс болгоомжилж CD, DVD-д буулган архивлан хадгалах нь зүйтэй.

Мэдээллийг боловсруулах, нэгтгэн дүгнэх

Судалгааны зорилго болон, мэдээлэл цуглуулахаар сонгосон аргуудтай уялдуулан цуглуулсан мэдээллийг тоон болон тоон бус шинжээр илэрхийлэгдэх байдлаар нь ангилан дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

Тоон мэдээлэл:

Тоон мэдээлэл нь ихэвчлэн анкетын аргаар цуглуулсан мэдээлэл байдаг бөгөөд ийм төрлийн мэдээлэлд нийгмийн судалгааны мэдээллийг боловсруулдаг тусгай программын аргаар математик, статистик шинжилгээ хийнэ. Үүнд:



- Мэдээллийг шалган, шаардлага хангасан анкетыг ялган дугаарлах, кодлох.
- Компьютерт мэдээллийн загварыг бэлтгэж, тоон утгуудыг шивж оруулна.
- Компьютерт оруулсан мэдээллийг шалгаж, боловсруулалт хийхэд бэлтгэнэ.
- Мэдээллийн анхан шатны боловсруулалт хийж, шинж тэмдгүүдийн утгыг давтамж болон хувийн жингээр бодож гаргана.
- Асуулга дахь тодорхойлогч болон хамаарагдагч хэмжигдэхүүнүүдийг

бүлэглэн харьцуулсан бодолтыг хийж давтамж, хувийн жингээр хүснэгтлэн гаргана.

- Хэмжигдэхүүний дундаж хандлагууд /мода, медиан, математик дундаж гэх мэт/ болон дисперс, корреляцийн шинжилгээний бодолтуудыг хийж нарийвчилсан хамаарлыг тогтооно.

Чанарын мэдээлэл:

Чанарын мэдээлэл нь мэдээллийн тоон шинжид хувиргах боломжгүй хэлбэр юм.



Энд гол төлөв стандартчилагдаагүй, давтамжийн хувьд цөөн, санамсаргүй шинжтэй мэдээллүүд багтана. Тухайлбал: Иргэдээс ирж буй санал гомдол, бүлгийн ярилцлагын протокол, тодорхой үйл явц, захиа захидал, кино, баримт жишээг дурьдаж болно. Чанарын мэдээлэлд тоон болон чанарын аргаар дүн шинжилгээ хийнэ.

Чанарын мэдээлэлд тоон боловсруулалт хийх гэдэг нь мэдээллийг давтамж, давхцал ихтэй, тодорхой хэв загварт хэлбэржүүлэх боломжтой үед шинж тэмдгийн утгуудыг тоон утгад орлуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ. Давтамж, давхцал багатай, давхцал байгаа ч тоолж ашиглах боломжгүй, үндсэн мэдээллийг нэгдсэн хэлбэрт оруулах бололцоо багатай мэдээллийг чанарын буюу бичиг баримтыг шинжлэх аргуудын тусламжтайгаар шинжилнэ.

Бичиг баримтын судалгаанд бүтэц, үүргийн болон шалтгаан, үр дагаврын шинжилгээ, контент анализын шинжилгээг ашиглах бөгөөд шинжлэх ухааны судалгааны үндсэн арга болох бүлэглэх, ангилал, бичиглэн тоочих зэрэг анализ, синтез, индукц, дедукцийн аргуудыг голлон хэрэглэнэ.

Ингэхдээ дараах үе шат бүхий аргачлалаар явуулна. Үүнд:

1. Холбогдох бүх мэдээллийн жагсаалтыг гаргана.
2. Мэдээллийг хэлбэр болон эх сурвалжаар нь төрөлжүүлэн ангилна. Тухайлбал,
 - Хууль, тогтоомж, эрх зүйн актууд
 - Төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа
 - Эрдэм шинжилгээний бүтээл, ном, зохиол
 - Эмпирик судалгааны дүн тайлан
 - Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар цуглуулсан мэдээлэл
 - Статистик тоо, мэдээлэл
 - Тодорхой асуудлаар бүртгэгдсэн албаны мэдээлэл /гэмт хэрэг, салалт, хүчирхийлэлтэй холбоотой шүүх, цагдаагийн мэдээлэл, өрхийн бүртгэл г.м./
 - Тухайн асуудлаар зохион байгуулсан бага хурлуудын илтгэл, хүмүүсийн хэлсэн үг г.м.
 - Төрийн бус олон нийтийн болон олон улсын байгууллагуудын хүрээнд гэр бүлийн асуудлаар явуулж буй төсөл, тодорхой үйл ажиллагааны тухай мэдээлэл г.м.
3. Мэдээллийг агуулгын чиглэлээр нь:
 - Үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт
 - Үйлчилгээний ажилтны хариуцлага, мэдлэг, чадвар

- Үйлчилгээний соёл, зан харилцаа
- Үйлчилгээний удирдлага
- Үйлчилгээний хүндрэл, бэрхшээл, гажуудал

4. Цаг хугацааны байдлаар нь:

- Өнгөрсөн
- Одоо
- Ирээдүй

5. Мэдээллийн хэлбэрийн хувьд:

- Бодлогын ба хэрэгжилтийн
- Онолын ба эмпирик

6. Судлаачийн нэмэлт шинжилгээ

- Бүтэц ба үүргийн шинжилгээ
- Шалтгаан ба үр дагаврын шинжилгээ
- Утгын задлан шинжилгээ
- Нэгтгэн дүгнэх
- Баримтаас өөрийн дүгнэлт хийх
- Өөрийн дүгнэлтийг баримтаар батлах

7. Логик үндэслэл бүхий загвар буй болгоно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цуглуулсан баримт мэдээлэлд контент анализын аргыг ашиглана. Тухайлбал, сонинуудын мэдээллийг ашиглахдаа:

- Мэдээлэл өгөгчийн нийгэм, хүн ам зүйн шинжийг тодорхойлох, бүлэглэх
- Мэдээлэл өгөх болсон шалтгаан, зорилгыг тодруулах, бүлэглэх
- Мэдээллийн агуулгын хувьд тавих шаардлагуудыг ангилах, жагсаахын зэрэгцээ зар өгсөн сонин, нийтлэгдсэн цаг хугацаа зэргийг анхааран үзнэ.



Бичиг баримтын шинжилгээг хийхдээ судлаач дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Түүврийн төлөөлөх чадварыг гол болгодоггүй тул бага хэмжээний мэдээлэлд ч ач холбогдол өгөх
- Мэдээллийн үнэн бодит байдал, эх сурвалжийн найдвартай байдалд анхаарах
- Ямар нэгэн урьдчилсан төсөөлөл, онол, үзэл сурталд тулгуурлахгүй байх

Мэдээллийг боловсруулахдаа математик, статистик аргыг ашиглахгүй тул судлаачдын мэдлэг, ур чадвар, туршлага, зөв сэтгэлгээнд илүү анхаарах хэрэгтэй.

Мэдээллийг нэгтгэн дүгнэх

Тоон болон чанарын мэдээллүүдийг нэгтгэн, харилцан уялдаа холбоонд нь авч үзнэ. Ингэхдээ:

- Мэдээллүүдийн зөрүүтэй байдал
- Мэдээллийн давхцах байдал
- Харилцан уялдах, бие биеэ нөхөх байдалд дүн шинжилгээ хийн, шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримтаар баяжуулан эцсийн үр дүнг гаргана.

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Мониторингийн гол бүтээгдэхүүн нь тайлан байдаг. Мониторингийн мэдээ баримт цуглуулах, судалгаа хийх ажил эцэслэн дууссаны дараа тайлан бичихийн зорилго нь:

- Нөхцөл байдлыг үнэн бодитой дүрслэн тодорхойлж, дүн шинжилгээ хийх.
- Зөрчлийн тодорхой нотолгоог гаргах.
- Дүгнэлтэд үндэслэн нийгэм, улс төр, хууль эрх зүйн хүрээнд тодорхой арга хэмжээ авах замаар эерэг өөрчлөлт бий болгоход чиглэсэн зөвлөмж гаргах.
- Олон нийтийг тухайн асуудлаар гэгээрүүлэх.
- Тухайн ТББ-д найдах донор, дэмжигчид, олон нийтийн итгэл үнэмшил бий болгох (баттай баримтад тулгуурласан, объектив, нэг талыг хэт баримтлаагүй тайлан тухайн мониторинг гүйцэтгэгч байгууллагын нэр хүнд өсөхөд тустай).

Тайлангийн найдвартай байдал

Тайлан нь гагцхүү үнэн зөв, бодитой мэдээллийг агуулах ёстой. Тоо баримт бүрийг тайланд оруулахаас өмнө шалгаж, давхар нягтлах ёстой. Хэдийгээр эх сурвалжийг нь тайланд тусгаагүй ч гаргаж тавьсан бүх мэдээллийг маш сайн баримтжуулсан байх ёстой.

Ямарваа мэдээллийн талаар төдийлөн итгэлтэй биш бол тайландаа тусгахгүй байх нь зүйтэй. Хэрэв тайландаа оруулахаар болбол энэ нь баталгаат бус мэдээлэл эсвэл ганцхан гэрчийн мэдүүлэг гэдгийг тодорхой заах ёстой.

Тайлангийн хэлбэр

Тайланд зайлшгүй чухал мэдээллийг оруулахаас гадна уг чухал мэдээллийг уншигчдад хүрэх аль болох энгийн арга ба хэлбэрээр бичнэ. Үүнд:

- Энгийн боловч ярианы бус хэлээр бичих,
- Мэргэжлийн нэр томъёо хэрэглэх, гэхдээ мэргэжлийн этгээд хэллэг хэрэглэхгүй байх,
- Факт баримт болон түүний тайлбарын хооронд зааг гаргах, үйл баримтыг эхэнд нь дурдах,
- Гадаад хэллэг хэт олон хэрэглэхгүй байх,
- Сэтгэлийн хөдлөл бүхий дүрслэлээс зайлсхийх,
- Ерөнхий, тодорхой бус дүгнэлтээс татгалзах.

Мониторингийн сайн тайлан нь харьцангуй богинохон хэдий ч бүхнийг хамарсан байх бөгөөд мэдээлэл, нотолгоо, нотлох баримт болон үйл баримтын талаар богино тайлбар агуулсан байх ёстой. Түүнчлэн тайлангийн найруулгыг сайн хянаж, үг үсгийн алдааг шалгасан байх нь чухал.

Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах

Мониторингт хамрагдсан байгууллагуудын ажилтнуудын хувьд тэдний нэрийг тайланд тусгадаг. Заримдаа тайланд орсон мэдээллийг нэрээ хэлэхийг хүсээгүй хүмүүсээс нууцлалын нөхцөлөөр өгсөн байдаг тул мэдээллийн эх сурвалжаа эрсдэлд оруулахгүйн тулд тэдний нэрийг кодлож, тэднийг таних боломжгүй болгоно. Хэрэв тэдний байдлыг дүрсэлснээр уг хүмүүсийг таних боломжтой болгон, улмаар эрсдэлтэй байдалд оруулах нөхцөл бүрдэж байвал тэрхүү мэдээллийг тайландаа тусгахгүй байж болно.

Мониторингийн тайлангийн бүтэц

1. Гарчиг

Гарчиг нь бүх асуудлыг агуулсан бөгөөд анхаарал татахуйц байх нь зүйтэй. Хэсэг болон дэд хэсгүүдийн гарчиг нь хэт ерөнхий байх зохимжгүй.



2. Талархал


Тайланг гаргахад хувь нэмэр оруулсан хүмүүст талархах (зохиогчийн эрхийн талаархи нүүр хуудас, оршил хэсэгт эсвэл оршлын өмнөх нүүрэнд талархлын тусгай нүүр гаргана). Үүнд мэдээ баримтыг боловсруулахад тусалсан хувь хүмүүс, мониторингийн багийн гишүүд болон сайн дурынхан багтана. Хэрэв тухайн хүнд аюултай нөхцөл байдал үүсгэх бол нэр дурдах шаардлагагүй.

3. Оршил

Оршлын эхэнд байгууллага болон мониторингийн зорилгыг товч танилцуулна. Мониторинг хийх болсон шалтгаан, судалгааны зүйл, хугацаа, ямар жишээг ашигласан, багийн бүрэлдэхүүн зэргийг маш товч дурдана. Оршилд мониторингийн үндсэн дүгнэлтээс оруулна.

4. Товч агуулга

Товч агуулга нь богино байх ёстойгоос гадна мониторингийн судалгааны хамгийн чухал дүгнэлтийг агуулсан байх нь зүйтэй. Уг тайлангийн зориулагдсан хүмүүсийн ихэнх нь гагцхүү энэ хэсгийг унших учир товч агуулгыг сайн бичих ёстой. Судалсан салбарынхаа гол асуудлууд болон илрүүлсэн зөрчлийг нэг нүүр эсвэл дээд тал нь хоёр нүүрэнд жагсаана. Хаалтан дотор тухайн асуудлын талаар бичсэн тайлангийн хуудасны дугаарыг зааж болох юм.



Товч агуулга нь маш сайн бодож бичсэн, бодитой байхын зэрэгцээ гагцхүү тухайн сэдвээ хөндсөн байх ёстой. Агуулга болон хэлбэр нь цаашид авах гэж буй арга хэмжээний зорилготойгоо уялдахаас гадна тайлан хүрэх хүмүүст / иргэд, албан хаагчид, олон улсын байгууллагууд г.м/ хандсан байна.

5. Улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын ерөнхий танилцуулга

Мониторинг хийсэн салбар болон чиглэлтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлыг дүрслэн харуулах. Хэт нуруу байхаас зайлсхийх нь зүйтэй.

6. Мониторинг хийхэд баримталсан холбогдох хуулийн заалтууд

Мониторинг хийхэд баримтлал болгосон олон улсын гэрээ, конвенци, Монгол Улсын хууль, дүрэм, журам, тогтоол заавар зэргийн холбогдох заалтуудыг тоочин, тайлбарлах

7. Мониторингийн танилцуулга: Танилцуулгад дараах мэдээллүүдийг багтаан оруулна.

- Төслийн нэр
- Төслийн үндсэн зорилго
- Төслийн үндсэн зорилт
- Хамарсан хугацаа болон хүрээ, байршил
- Мониторингийн багийн бүрэлдэхүүн

8. Мониторингийн аргачлал

Мониторингийн аргачлалаа дэлгэрэнгүй тайлбарлах. Тухайлбал, анкетын арга ашигласан бол ямар түүвэр судалсан, зорилго нь юунд чиглэсэн болохыг товч бөгөөд тодорхой тайлбарласан байна.

9. Мониторингийн дүн



Мониторинг хийсний үр дүнд гарсан тухайн салбар, чиглэлийн зөрчлийн факт, баримт, мэдээллийг жагсаан, түүндээ анализ хийх. Үүнд, олсон баримт фактуудаа шалгуур үзүүлэлт тус бүр дээрээ задлан тайлбарлана. Нотлох материалаасаа эдгээр фактуудаа иш татан оруулах. Жишээ нь протокол, тэмдэглэл, авсан зураг гэх мэт.

Мониторингийн дүнг гаргахдаа зөвхөн өөрсдийн таамаглалыг батлах бус, харин судалсан үзэгдлийнхээ үнэн дүр зургийг гаргаж ирэхийг хичээх ёстой.

Тайланд дараах мэдээллийг заавал багтаана. Үүнд:



- Бодит жишээ буюу кейс оруулан дүрслэх. Гэхдээ хэт сэтгэлийн хөдөлгөөнөөр илэрхийлэх бус үйл баримтыг харуулах.
- Мониторингийн ярилцлага өгсөн хүмүүсийн үгнээс иш татах оруулах.
- Мониторингоор цугларсан тоо баримт.
- Холбогдох статистик тоо баримт.

Тоо баримтыг иш татахдаа дараах зүйлсийг санахад илүүдэхгүй:

Мэдээ баримтыг ойлгомжтой, ил тод байдлаар, уншихад хялбар хүснэгт, диаграм, схем зэрэг хэлбэрээр гарган тавих ёстой.

Статистик мэдээ баримт, хүснэгт, диаграмм, схем зэргийг нэг адил хэлбэрээр, ойлгомжтой харуулах нь зүйтэй.

Хүн амын тоо болон статистик (жишээ нь судалгаанд хамрагдсан бүлэг) хэмжээг тухай бүр заах ёстой.

10. Дүгнэлт ба цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж

Тайланд дүгнэлт ба зөвлөмжийн хооронд тодорхой зааг гаргана. Дүгнэлтийг зөвхөн үйл баримт дээр тулгуурлан гаргадаг бол зөвлөмжийг тайланг гаргагчдын үзэл бодол дээр тулгуурладаг. Тайлангийн дүгнэлтийг гаргахдаа мониторингийн дүнг товчлон тоочихоос гадна зөрчил гарах болсон шалтгаан, хүчин зүйлийг тайлбарлана.

Зөвлөмжид судалсан салбар дахь байдлыг хэрхэн сайжруулах талаар тодорхой арга замыг санал болгоно. Үүнд хууль эрх зүйн орчныг өөрчлөх эсвэл бүтцийн өөрчлөлт хийх, бусад ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар дурьдана. Зөвлөмж нь хууль тогтоох, гүйцэтгэх, буюу шүүх эрх мэдэл, орон нутгийн удирдлагын байгууллагууд эсвэл олон улсын байгууллагад хандсан байна. Үүндээ эдгээр байгууллагаас тодорхой нэр заан оруулах нь зүйтэй байдаг.

11. Ном зүй

Ном зүй нь судалгаа явуулах болон тайлан бичихдээ ашигласан бүх нийтлэл, өгүүллийн жагсаалт юм. Тайланд оруулсан бүх ишлэлийн доор холбогдох эх сурвалжийг нь заах ёстой.

12. Хавсралт

Тайланд тухайн хөндсөн асуудлын мөн чанар болон тэдгээрийг судлахын тулд ашигласан аргыг ойлгоход хэрэг болох бүх материалыг хавсаргах нь зүйтэй. Жишээлбэл:

- Мониторингт хамрагдсан тодорхой байгууллагуудын жагсаалт
- Мониторингт оролцсон хүмүүсийн нэрсийн жагсаалт
- Мониторингт ашигласан арга хэрэгслийн жишээ
- Эрх зүйн холбогдох актын бүтэн эх
- Мониторинг хийгдсэн салбарт хамаарах бусад баримт бичиг
- Шинжээч мэргэжилтнүүдийн судалгаа
- Тухайн байдлыг харуулсан диаграмм
- Объект болон материаллаг нотлох баримтын гэрэл зураг
- Бусад мэдээлэл

13. Үгийн товчлол

Зарим тодорхой байгууллага болон хууль тогтоомжийн нэрсийг товчлон, энэхүү товчлолын үгтэйлбарыг хавсаргах нь зүйтэй.



НӨЛӨӨЛӨЛ



УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

НӨЛӨӨЛӨЛ

Нөлөөлөл гэж юу вэ?

Төр засгаас боловсруулан хэрэгжүүлж буй бодлого, иргэдэд хүргэж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд илэрсэн алдаа дутагдал, зөрчил гажуудлыг ямар хөшүүрэг, арга хэрэгсэл ашиглан сайжруулж болох талаар зорилго тавин, төлөвлөгөө боловсруулж, тодорхой стратегид тулгуурласан үйл ажиллагаа явуулахыг нөлөөлөл гэж ойлгоно.



Нөлөөллийн үйл ажиллагааны амжилтын эх нь нөхцөл байдлын бодитой үнэлгээ, батлах баримт нотолгоо, зөрчлийг хэрхэн засаж залруулах талаар гүйцэтгэх боломжтой шийдэл зэрэг мөн.

Нөлөөллийн үе шатууд

Нөлөөллийн үйл ажиллагаа нь дараах үе шатуудаас бүрдэнэ. Үүнд:

1-р үе шат: Нөлөөллийн объектыг сонгох (тухайлбал шийдвэр гаргах, тухайн асуудлыг зохистой шийдвэрлэхэд нөлөөлөх чадамж, эрх мэдэл бүхий албан тушаалтан), тэдний мониторингийн асуудалд хандах сонирхол, хандлагыг нь судалж тогтоох. Нөлөөллийн объектын хандлагыг тодорхойлох буюу судлахад дараах асуултуудыг чиглэл болгож болно:

- Танай байгууллагатай хэр танил болох (өмнө нь ямар нэг байдлаар хамтран ажиллах буюу бусад байдлаар холбогдох тохиолдол байсан эсэх, тийм бол ямар зорилгоор хэрхэн холбогдож байсан болох)
- Нөлөөллийн сэдэв болох асуудлын талаар хэр мэдлэгтэй вэ? (энэ талаар үнэн зөв мэдээлэлтэй эсэх, эсвэл мэдээлэл дутмаг байдаг уу?)
- Тухайн асуудлын талаар танай байгууллагатай санал нийлэх эсэх (Танай байр суурийг дэмжих үү? Эсэргүүцэх үү? Дундыг баримтлах уу?)
- Өмнө нь энэ талаар үзүүлсэн дэмжлэг хэр вэ? (Тухайн асуудалтай холбоотой танай байр суурийг дэмжиж байсан тохиолдол бий юу? Байгаа бол ямар байдлаар?)

Нөлөөллийн объектыг сонгож авахдаа бодлого боловсруулагч, түүнийг хэрэгжүүлэгчдийн хоорондын ялгааг харгалзах нь чухал. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд аль шатны ямар хүмүүсийн шийдвэр оролцоо чухал болохыг сайтар эргэцүүлэх хэрэгтэй. Зарим тохиолдолд хууль, эрх зүйн зохицуулалт хангалттай боловч амьдрал дээр хуулийг хэрэгжүүлэхдээ гуйвуулж, завхруулдаг дутагдал байж болно. Ийм тохиолдолд нөлөөллийн объектыг хуулийг хэрэгжүүлэх түвшний эрх мэдэлтнүүдээс судлан сонгох шаардлагатай болно.

Жишээ:

Бодлого уу? Хэрэгжилт үү?

Балба Улсад хүүхдийн эрхийг хамгаалах талаар баталсан хуулиуд хангалттай бөгөөд энэ талаар санаа тавьдаг улс төрчид цөөнгүй хэдий боловч эдгээрийг хэрэгжүүлэх талаар санаачлага дутагдалтай байсаар иржээ.

Энэ тохиолдолд нөлөөллийг бодлого боловсруулагчдад бус хэрэгжүүлэгчдэд хандуулах шаардлагатай нь ойлгомжтой байна. Ингэхдээ бодлогыг хэрэгжүүлэхэд саад болж байгаа хүчин зүйлүүдийг судлахаас нөлөөллөө эхлэнэ. Юуг өөрчлөх шаардлагатай байна? Нөөц бололцоо, хөрөнгө мөнгө дутагдалтайгаас хууль биелэхгүй байна уу? Соёл, ёс заншлаас улбаатай юу? Авилга саад болоод байна уу? Улс төрчдийн “сэтгэл” дутаж байна уу? Эдгээр асуултуудын хариултад үндэслэн нөлөөллийн стратеги нь хуулийг завхруулагчдыг хянах хяналтыг сайжруулах талаар удирдах хүмүүстэй нь хамтарч ажиллах, эсвэл тухайн асуудлын талаар олон нийтийн итгэл үнэмшил, хандлагыг өөрчлөхөд чиглэнэ.

*Боловсролын бодлогод нөлөөлөх нь гарын авлага
Хүүхдийг Ивээх Сан*



Төрийн үйлчилгээ хүргэдэг тодорхой байгууллагыг нөлөөллийн объект болгон сонгосон бол, тухайн байгууллагад шийдвэр гарган нөлөөлөх чадамжтай ямар хүмүүс байгааг олж тогтоох нь ач холбогдолтой. Шийдвэрлүүлэх асуудлын онцлогоос буюу нөлөөллийн тодорхой зорилтоос шалтгаалан энэ нь байгууллагын ямар ч түвшний албан тушаалтан байж болох бөгөөд заавал хамгийн дээд албан тушаалтан байх албагүй. Иймд эрх мэдлийн тогтолцоонд хэн нь тухайн асуудлыг бодитой засч шийдвэрлэх чадамжтай болохыг сайтар судлан тогтоох нь хичнээн чухал болох нь ойлгомжтой байна.

2-р үе шат: Нөлөөллийн асуудалд хамаатай оролцогч талуудыг олж тогтоох, тухайн асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажиллах, дэмжлэг авах, хүчээ нэг омж байгаа эсэхийг судлах. Үүнд, тухайлбал:

- Хамтрагчид- эерэг хандлагатай улс төрчид, албан тушаалтнууд
- Хэвлэл мэдээлэл
- Олон нийт
- Олон улсын байгууллагууд, донорууд
- Бизнесийнхэн
- Бусад ТББ-ууд гэх мэт

Эдгээр талуудын зарим нь эерэг хандлагатай, асуудлуудыг шийдвэрлэхэд бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчдэд шууд болон дам нөлөөлөх боломж, магадлалтай байж болох ба зарим нь таны гаргасан санаачлагыг эсэргүүцэж болох юм. Эсэргүүцлийг урьдчилан таамаглаж, хэрхэн саармагжуулах талаар нөлөөллийн төлөвлөгөөндөө тусгасан байх нь ач холбогдолтой. Ингэхийн тулд оролцогч талуудын тухайн асуудалд хандах хандлагыг сайтар судлан тогтоох шаардлагатай болдог.



Английн Хүүхдийг Ивээх Сангаас эрхлэн гаргасан нөлөөллийн гарын авлагад өгүүлснээр нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд дан ганц оролцогч талуудыг олж тогтоогоод сэтгэл амрах бус тэдгээр хүмүүс, хуулийн этгээдүүдийн талаар аль болох сайтар судалж, таньж мэдэх хэрэгтэй болохыг онцолжээ. Үүнд: оролцогч талуудын тухайн асуудлын талаарх мэдлэг, асуудалд хандах хандлага, итгэл үнэмшлийн байдал, хэрэв тухайн асуудалд ямар нэг хэлбэрийн сонирхол үгүй бол, юунд сонирхол нь оршиж байна г.м. Оролцогч талуудын талаар сайн мэдээлэлтэй байх тусам нөлөөллийн стратеги оновчтой болно.

Хүүхдийг Ивээх Сангийнхан нөлөөллийг оновчтой төлөвлөхөд дараах аргачлалаар объект болон хамаатай талуудыг судлахыг зөвлөжээ.

1. Нөлөөллийн зорилтуудаас сонгох
2. Нөлөөллийн объект болон хамаатай талуудыг жагсаах
3. Нөлөөллийн үйл явцтай холбоотой байж болох нөлөөллийн объект болон хамаатай талуудтай холбоотой бүх мэдээллийг тоочих

Жишээ нь:

- Нөлөөллийн зорилт нь сургалтын хөтөлбөр боловсруулагч албан тушаалтнууд нь хөтөлбөртөө хүүхдүүдийн саналыг заавал тусгадаг байх шаардлагыг үндэсний боловсролын бодлогод тусгуулах
- Бодлогод шаардлагатай өөрчлөлтийг оруулах чадамжтай этгээд буюу нөлөөллийн объект нь Боловсролын Яам

Үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу.


Жишээ нь:

Нөлөөллийн объект/ оролцогч талууд	Асуудлын талаар юу мэдэх вэ?	Хандлага	Сонирхол
1. Боловсролын Яам	Хүүхдүүд өөрсдөд нь нөлөөлөх аливаа шийдвэрт оролцох эрхтэй талаар сонссон нь дутмаг	Чухал асуудал биш Шийдвэр гаргах нь томчуудын ажил Хүүхдүүд зөв оновчтой шийдвэр гаргахад хэтэрхий балчирдана	Сонгуульд дахин ялах Дэлхийн Банкны дэмжлэг
2. Хэвлэл мэдээлэл	Дээрхтэй ижил	Огт сонирхдоггүй	Орлого, захиалгын тоо Сонирхолтой, шинэлэг мэдээ
3. Багш нарын холбоо	Өмнө нь хүүхдийн оролцооны талаар ТББ-уудын зохион байгуулсан сургалтад оролцож байсан	Холбооны гишүүдийн зарим нь хүүхдийн оролцоог дэмждэг, зарим нь эсэргүүцдэг	Шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөр нь багш нарын ажлын ачааллыг улам нэмж болзошгүй Хүүхдийн боловсролын талаар эксперт гэсэн статус нь суларч болзошгүй
4. Эцэг эх			

*Боловсролын бодлогод нөлөөлөх нь гарын авлага
Хүүхдийг Ивээх Сан*

Нөлөөллийн гол объект болон түүнд нөлөөлөх чадамжтай оролцогч талуудын хоорондын холбоог судлах нь дараагийн чухал алхам мөн.


Жишээ нь:



*Боловсролын бодлогод нөлөөлөх нь гарын авлага
Хүүхдийг Ивээх Сан*

Ийм маягаар дүрсэлж үзэхэд дээрх схемд орхигдуулсан нөлөөлөх чадамжтай бусад оролцогч талууд анзаарагдаж болзошгүй. Тухайлбал Дэлхийн Банк нь боловсролын бодлогын талаар зөвлөгөө өгөх үйл ажиллагаа явуулдаг болон боловсролтой холбоотой мэдээллээр хэвлэл мэдээллийнхнийг хангадаг ТББ-тай хамтран ажилладаг бөгөөд багш нарын холбоо нь, сөрөг хүчний намын удирдлагын ятгалгыг хүлээж авах магадлалтай байж болно. Энэ тохиолдолд дээрх схемд эдгээр талуудыг нэмж оруулах шаардлагатай.

Жишээ нь:



*Боловсролын бодлогод нөлөөлөх нь гарын авлага
Хүүхдийг Ивээх Сан*

Энэ маягаар схемчлэн харахад нөлөөллийн аль сувгаар дамжуулан объектод хүрч нөлөөлөх талаар төлөвлөгөө боловсруулахад хялбар болдог. Дээрх жишээнд үзүүлснээр нөлөөллийг хэрэгжүүлж буй байгууллага нь Боловсролын сайд болон багш нарын холбоотой шууд харилцаа байхгүй ч сөрөг хүчний удирдлагаар дамжуулан багш нарын холбоонд нөлөөлөх, улмаар тэднээр дамжуулан Боловсролын сайдад нөлөөлөх боломжтой нь харагдаж байна.

3-р үе шат: Нөлөөллийн объектод чиглэсэн оновчтой бөгөөд товч тодорхой “мессеж” бэлдэх, түүнчлэн ямар сувгаар дамжуулан уг мессежээ хүргэх хүртээх талаар стратеги боловсруулах.

Тухайлбал: Улаанбаатар хотын агаарын бохирдол, утааны асуудлыг шийдвэрлэх талаар бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийн санаачилга, үйл ажиллагаанд шахалт үзүүлэх зорилгоор Монголын өдөр тутмын сонинууд нэгдэн “Улаанбаатарын утаа гамшгийн байдалд хүрээд байна” гэсэн гарчгийн доор хэд хэдэн захидал, нийтлэл бичсэн нь хүмүүсийн “чихэнд наалдсан,” тулгамдсан асуудлыг товч, оновчтой тайлбарласан жишээ мөн.



Америкийн CEDPA хэмээх байгууллагаас гаргасан нөлөөллийн талаар гарын авлагад нөлөөлөлд зориулсан мессеж нь бодлого боловсруулагчдын сонирхолд нийцэж байвал үр дүнд хүрэх магадлал өндөр байдаг талаар зөвлөөд ийм мессеж бэлдэхийн тулд тухайн нөлөөлөхөөр завдаж буй асуудалд бодлого боловсруулагч хэрхэн хандаж ирсэн болон ямар үзэл бодолтой явдаг талаар судалж, мэдээлэл цуглуулах нь зүйтэй гэжээ.

Жишээ:

Мэдээллийн эрх чөлөөний хууль гаргахад олон нийтийн дэмжлэгийг олж авахын тулд иргэдэд хандсан дараах мессежийг ашиглажээ.

Иргэн!

Та төрөө сонгодог

Та төрөө санхүүжүүлдэг

Та төрийн хэрэгт шууд оролцох эрхтэй

Та төрөө хянах шүүмжлэх эрхтэй

Үүний тулд Та мэдэх эрхтэй

Мэдэхийн тулд мэдээлэлтэй байх эрхтэй

Иймд танд мэдээлэл хүртэх хууль хэрэгтэй!

Мэдэх эрх. Глоб Интернэйшнл, 2003 он, 3 дахь тал

Нөлөөллийн мессежийн зорилго нь:

- Мэдээлэх
- Үйлдэлд хөтлөх
- Ятгах
- Арга хэмжээ авахад хүргэх

Нөлөөллийн мессежийн агуулгад дараах элементүүдийг багтаавал илүү хүчтэй байдаг. Үүнд:



Тухайлбал CEDPA-ын нөлөөллийн талаар гарын авлагад доорх сонирхолтой жишээг өгүүлжээ.

Асуудал (Асуудлын голыг олж хэдэн өгүүлбэрээр хэлэх):

Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийг зогсооё. Эмэгтэйчүүд ийм төрлийн хүчирхийллийг удаан хугацаанд чимээгүй тэвчсээр ирсэн. Үүнтэй холбоотой энэ асуудлын цар хүрээ, хор уршгийг үл тоомсорлох хандлага бий болжээ.

Баримт (Асуудлыг баримтаар баталгаажуулах, баримт нь “чихэнд наалдацтай” байх):

Америكت 8 секунд тутам нэг эмэгтэй хүн хүчирхийлэлд өртөж байна. 1992 оны Америкийн Сенатын Эрх Зүйн Хорооны гаргасан тайлангаас харахад манайд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нийт авто машины осол, хорт хавдраас үүдэлтэй нас баралтын тоо, дээрмийн хэргийн тохиолдлыг нийлүүлснээс илүү байна.

Жишээ (Баримтаа бодит амьдралын жишээгээр баяжуулах):

Манай байгууллагаас тусламж хүссэн Мария хэмээх эмэгтэй хэдхэн жилийн өмнө бусдаас дутахгүй ажил, амьдралтай нэгэн байсан бол гэрлэснээсээ хойш нөхрийнхөө хэрцгий авираас болоод амьдрал нь орвонгоороо эргэн ядуурсан байна. Энэ мэт гэр бүлийн хүчирхийлэл ямар хор уршигт хүргэдэг тухай энэ мэт олон жишээ байна.



Нөлөөллийн мессежийн агуулгыг хэнд хандаж байгаадаа тохируулан өөрчилж хүргэх нь үр дүнтэй тактик мөн. Ингэхдээ дээр дурдсанчлан мессежийг илгээх нөлөөллийн объектын ашиг сонирхол, хандлага зэргийг харгалзан үзэх нь чухал.

Жишээ:

Мессежийн агуулгыг нөлөөллийн объектын хандлагад нийцүүлэн өөрчлөх нь:

Энэтхэгийн Пратхам хэмээх хүүхдийн эрхийн байгууллага “ 2000 он гэхэд бүх хүүхдийг сургуульд жигд хамруулах” зорилго дэвшүүлэн нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь эцэг эхчүүд болон бизнесийнхэнд аль алинийх нь ашиг сонирхолд зэрэг нийцсэн, тэдний дэмжлэгийг хүртсэн үйл ажиллагаа болжээ. Гэхдээ Пратхамын санаачилсан энэхүү үйлсийг дэмжих болсон тэдний шалтгаан нь өөр өөр байв.

- Эцэг эхчүүдийн хувьд үр хүүхэддээ сайн сайхныг хүсэх нь тодорхой. Сургуульд сурж үр хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх нь тэдний ирээдүйд тустай болохыг тодорхой жишээгээр батлан ятгасан нь амжилттай болсон байна.
- Бизнесийнхний хувьд “эдийн засгийн хэл”-ээр ярилцах нь үр нөлөөтэй байв. Тэдний хувьд өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд боловсролтой хүний нөөц бий болгох нь чухал болохыг ятган ойлгуулах, ингэхийн тулд сургуулиудыг дэмжих үйл ажиллагаа явуулахыг уриалах арга хэрэглэсэн байна.

*Боловсролын бодлогод нөлөөлөх нь гарын авлага
Хүүхдийг Ивээх Сан*

4-р үе шат: Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, нөлөөллийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх.

Үүнд нөлөөллийн мессежээ хэнд, ямар хэлбэрээр, хэрхэн, хаана, хэзээ, хэнээр дамжуулж (эсвэл шууд) хүргэх вэ гэсэн асуудлууд багтана. Ингэхдээ цаг үе, байж болох таатай боломжийг аль болох овсгоо самбаатай ашиглахыг эрмэлзэх нь зүйтэй.



Нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад сонгуулийн үе хамгийн тохиромжтой үе болж таарах нь бий. Энэ үеэр улс төрчид сонгогч иргэдийнхээ санал хүсэлтийг сонсохдоо илүү “чих зөөлөн” хандах байдал ажиглагддаг.

Нөлөөллийн үйл ажиллагаанд янз бүрийн арга хэрэгсэл ашиглах боломжтой бөгөөд тухайн нөхцөл байдлын онцлог болон улс орны улс төр, нийгмийн ерөнхий байдлаас хамааран ямар арга хэрэгсэл хамгийн тохиромжтой, үр дүнтэй болохыг тодорхойлно. Үүнд зарим нэг жишээг дурдвал:

Хэвлэл мэдээлэл: Мониторинг хэрэгжүүлснээр олж авсан баримт мэдээллийг аль болох өргөн хүрээнд тараах, олон нийтийг гэгээрүүлэх, энд хэвлэл мэдээллийнхнийг татан оролцуулах:

- ТВ, сонинд ярилцлага өгөх
- Тайланг сонинд хэвлэх
- Хэвлэлийн бага хурал зохион байгуулах гэх мэт.



Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Эрх Зүйн Санаачилгаас ТББ-уудад зориулан гаргасан “Авилгалын эсрэг мониторингийг хэрхэн ашиглах тухай” гарын авлагад үр дүнтэй нөлөөлөлд хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах нь өндөр ач холбогдолтой байдаг талаар онцолжээ.

Хүмүүсийн санаа бодол, итгэл үнэмшилд нөлөөлөхөд хэвлэл мэдээлэл хамгийн тохиромжтой арга хэрэгсэл мөн боловч ийм сувгаар мэдээлэл дамжуулахад зарим нэг зүйлийг анхаарах нь чухал. Тухайлбал: хэвлэлийнхэнд мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар, судалгааны дүнг аль болох товч тодорхой хялбар уншигдахаар буулгах нь хамгийн оновчтой. ТББ-ууд ихэвчлэн хэвлэлийн бага хурал зохион байгуулж хэвлэлийн мэдээлэл буюу press release бэлтгэн гол санаа буюу нөлөөллийн мессежээ нэг хуудсанд багтаан сэтгүүлчдэд тараах арга хэрэглэдэг.

Ямар ч ээдрээтэй асуудлыг радио телевизээр хүргэхдээ шууд бөгөөд энгийн үг хэллэг ашиглан танилцуулах нь үзэгч, сонсогчдод илүү хүрдэг. Хэвлэл мэдээллийнхэн тодорхой асуудлыг нарийвчлан, гүнзгий ээдрээтэй тайлбарласан мониторингийн тайланг сонирхох эсэх нь эргэлзээтэй. Тиймд тэдний сонирхлыг аль болох татах “өнцгөөс” асуудлаа танилцуулж, мэдээллээ нэвтрүүлэх боломж хайх хэрэгтэй. Жишээ нь, тухайн зөрчилтэй байдал амьдралд жирийн иргэд болон хүүхдийн амьдралд хэрхэн тусч, холбогдож буй талаар бодит байдалд ойр жишээнд үндэслэн ярьж болно. Эцэст нь сонин, хэвлэл, радио, телевизээр нэг удаа харагдаж сонсогдоод өнгөрөх биш нөлөөллийн зорилт биелэх хүртэл тодорхой хугацаанд дуу хоолойгоо хүргэсээр байхын тулд зардал бага шаардагдах арга замуудыг эрэлхийлэх нь зүйтэй. Тухайлбал, хэвлэл мэдээллийнхний оролцсон хурал, хэлэлцүүлэг гэх мэт үйл ажиллагааны үеэр санал бодлоо илэрхийлэх гэх мэт.

Хамтын ажиллагаа санаачлах: Албан тушаалтнуудтай уулзах, мониторингийн дүнг танилцуулах, боломжтой бол зөрчлийг засаж залруулах талаар хамтран ажиллах. Үүнд:

- Шийдвэр гаргагчтай ганцаарчлан уулзах
- Илгээлт бичиг явуулах
- Албан тушаалтнуудыг оролцуулан хурал, семинар хэлэлцүүлэг зохион байгуулах

Ийм аргаар нөлөөлөл явуулахдаа гол зорилго нь өөлж муулах, зааж сургах биш нэгдмэл байр сууринаас хамтран ажиллаж, зөрчлийг засаж залруулах юм гэсэн итгэлцлийг бий болгох нь нэн чухал юм.

Ижил төстэй зорилго бүхий байгууллагуудтай түншлэх: Нөлөөллийн үйл ажиллагааг түншлэх байдлаар хамтран зохион байгуулах хэцүү хэдий ч ач холбогдолтой арга мөн. Тухайлбал:

- Мэдлэг туршлага сургамжаасаа хуваалцах боломжтой болно.
- Урьд нь байгаагүй боломж, эх сурвалжууд нээгдэх сайн талтай / санхүүжилт г.м/.
- Хэд хэдэн байгууллагууд нэгдэж дуугарах нь ганцаараа дуугарахаас илүү нөлөөтэй байх магадлалтай /шинээр байгуулагдсан олон нийтэд хараахан танигдаж амжаагүй жижиг байгууллагуудын хувьд энэ нь бүр ч ач холбогдолтой/
- Сүлжээнд холбогдох, түнштэй байх нь урам зориг нэмж, өөрийн хүчинд итгэх итгэл өгдөг
- Хамтран ажилласнаар иргэний нийгмийн нэгдмэл байдал, нийгмийн сайн сайханд нөлөөлөх хүч улам нэмэгдэнэ.

Түншлэл гэдэг нь талууд адил тэгшээр хамтран ажиллахыг хэлнэ. Нөлөөлөлд оруулах хувь нэмэр нь харилцан адилгүй байж болох ч, адил тэгш байдал нь түншлэлийн ноён нуруу байдаг. Түншлэлийг эхлэхэд юуны өмнө гол асуудал, зорилго, зорилтын талаар нэгдмэл байр суурьтай байх нь чухал. Хамтын ажиллагаандаа нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлах нь түншлэл цаашид удаан хугацаанд үргэлжлэх үндэс болдог.

Хамтын ажиллагаанаас гадна түншлэлийн арай энгийн хэлбэр нь сүлжээ үүсгэх буюу мэдээлэл байнга солилцож бие биенийхээ ажилд дэмжлэг үзүүлэх явдал юм. Мэдээлэл солилцсоноор бусдын арга туршлага, алдаа сургамж, мэдлэг чадвараас үйл ажиллагаандаа тусган авч хэрэгжүүлэх боломж үүснэ.

Олон нийтийг хамруулсан кампанит ажил зохион байгуулах: Олон нийтийг оролцуулсан арга хэмжээ зохион байгуулах (суулт, ажил хаялт, жагсаал цуглаан, дэмжигчдийн гарын үсэг цуглуулах гэх мэт)

Ийм төрлийн кампанит ажил нь богино хугацааных байдаг бөгөөд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдийг ятгах магадлалтай хэдий ч нөлөөлөх чадамжтай гол хүмүүсийг зай барьж, улмаар болгоомжлох байдалд хүргэж болзошгүй. Иймд энэ аргыг сонгохдоо болгоомжтой бөгөөд хянуур байж шийдвэрээ зөв гаргах нь чухал. Ийм төрлийн үйл ажиллагааг удирдахад төвөгтэйн зэрэгцээ хөрөнгө мөнгө шаардлагатай болохыг бодолцох хэрэгтэй. Хэрэв кампанит ажлыг нөлөөллийн арга хэрэгсэл болгон сонгож авбал энэ нь танай байгууллагын урт хугацааны зорилгод хэрхэн нөлөөлөх талаар эрэгцүүлж үзэхэд мөн илүүдэхгүй.

Бусад аргууд:

- Хууль эрх зүйн хүрээнд тодорхой кейсд үндэслэн стратегийн өмгөөллийн арга хэрэглэх



Стратегийн өмгөөлөл гэж юу вэ?

Тулгарсан асуудлаа шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтэй иргэдийг төлөөлөн хууль эсвэл түүний хэрэглэж буй практикийг өөрчилж, нийгэмд нөлөөлөх зорилготой өмгөөллийн үйл ажиллагааг стратегийн өмгөөлөл гэнэ. Өөрөөр хэлбэл, стратегийн өмгөөлөл нь нийгэм, эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлд чиглэсэн өмгөөллийн үйл ажиллагаа юм.

*Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь
Нээлттэй Нийгэм Форум*

- Хууль эрх зүйн хүрээнд бодлогыг өөрчилж сайжруулах, шинээр хууль батлуулах зорилгоор лоббидох. Үүнд туршлага, чадвар шаардлагатай.

Нөлөөллийн явцыг хянах, дүгнэх

Нөлөөллийн явцыг хянахын ач холбогдол

Нөлөөллийн хүрээнд хийх ажлаа системтэй төлөвлөснөөр үйл ажиллагаагаа эхлүүлэх нь зүйтэй гэдгийг өмнө дурдсан. Энэхүү төлөвлөгөөндөө зайлшгүй тусгах ёстой нэгэн зүйл бол ажлын явцад үнэлгээ хийх цаг хугацаа юм. Ингэснээр төлөвлөгөөний биелэлт, ажлын явц ямар байгаагаас шалтгаалан өөрчилж засах зүйл байгаа эсэхийг нягтлах боломжтой болно.

Төлөвлөгөөнд тусгагдсан үнэлгээний хугацаанаас гадна нөлөөллийн явцад анхны гаргасан төлөвлөгөөгөө ерөнхийд нь байнга эргэн харж засвар өөрчлөлт хийх шаардлага байгаа эсэхийг тогтоож байх нь чухал. Тухайлбал, нөхцөл байдлаас шалтгаалан шинэ соргог баримт баталгаа олох шаардлага гарч болзошгүй. Сонгууль болж өнгөрсний дараа засгийн газрын бүтэц шинэчлэгдэж, түүнтэй хамт нөлөөллийн объект өөрчлөгдөх боломжтой. Шинэ хууль батлагдаж, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол нөлөөллийн зорилтуудаа эргэн харж, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг хянах зайлшгүй шаардлага гарч ирнэ. Төлөвлөгөөний дагуу ажиллах явцад хэр зэрэг амжилттай яваа, хийж гүйцэтгэсэн ажил үр дүнгээ өгч байгаа эсэхийг байнга эргэн харах хэрэгтэй. Үйл ажиллагааны зарим нь төлөвлөснөөс илүү зардал шаардсан бол төсвөө төлөвлөгөөндөө ахин нийцүүлэх шаардлага ч гарна.




Нөлөөлөл нь уян хатан процесс учраас түүнийг гүйцэтгэж буй хүмүүс орчин тойронд нь байнга тохиолдож буй өөрчлөлтүүдийг харгалзан стратеги төлөвлөгөөгөө тохируулан шинэчилж байх нь амжилтад хүрэхэд чухал нөлөөтэй.

Нөлөөллийн явц, үр дүнг үнэлэх аргууд

Нөлөөллийн ажлын явц, үр дүнг үнэлэх хэд хэдэн арга байдаг.

- Харьцуулах, дагалдах судалгаа

Ямар өөрчлөлт гарсныг хэмжих хамгийн шалгарсан арга бол нөлөөлөл эхлэхээс өмнөх нөхцөл байдлыг нөлөөлөл дууссаны дараа байгаа тоо баримттай тулгаж харьцуулах арга юм. Жишээ нь: нөлөөлөл эхлэхээс өмнө ажилгүй байсан хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэдийн тоог нөлөөлөл дууссаны дараах тоотой нь харьцуулах гэх мэт. Түүнчлэн нөлөөллийн хамаатай талуудаас нөлөөллийн үр дүн хэрхэн амьдралд нь тусгалаа олж буй талаар тоон чанартай анкетын судалгаа хийж болно.



- Гол мэдээлэгчид, фокус бүлгийн ярилцлага

Нөлөөллийн үйл явцыг ойлгох, дүгнэх чадамжтай бүлэг хүний санал бодлыг сонсох чанарын аргыг ашиглаж болно. Эдгээр гол мэдээлэгчид нь /нөлөөллийн объект, оролцогч талуудаас оролцуулж болно/ өөр өөрийн “өнцгөөс” нөлөөллийн ажилд үнэлгээ өгөх чадамж бололцоотой байх ёстой. Жишээлбэл: сэтгүүлчдийн зүгээс таны нөлөөллийн ач холбогдлыг хэрхэн ойлгож байгаа, төрийн ажилтнуудын зүгээс улс төрчдийн хүрээнд хандлага хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар гэх мэт. Энэ мэтээр олон хүний санал бодлыг зэрэг сонсон дүгнэлт хийх зорилгоор фокус бүлгийн ярилцлага зохион байгуулж болно.

Үйл явцыг үнэлэх, нөлөөллийн үйл ажиллагааг дүгнэхтэй холбоотой зарим асуудлууд

- **Миний гавьяа мөн үү?**



Мониторингийн нөлөөллийн хүрээнд сайжруулахаар зорьсон нөхцөл байдалд мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарсан тохиолдолд түүний шалтгааныг өөрийн хийсэн ажилтай /тухайн үед болж байсан бусад үйл явдлыг тооцохгүйгээр/ хэрхэн холбох вэ? Өөрийн оруулсан хувь нэмрийг хэрхэн бодитой дүгнэх вэ? Эдгээр асуултууд нь өөрсдийн хийсэн ажлыг бодитой үнэлэхэд тустай. Тухайлбал, бодлогод гарсан өөрчлөлтийн шалтгаан

нь таны явуулсан захидлын мөрөөр авсан арга хэмжээ ман үү? Эсвэл тухайн асуудлын талаар гаргасан иргэдийн удаа дараагийн санал гомдол, сэтгүүлчдийн сурвалжлага, сонин хэвлэлийн нийтлэлүүд өөрчлөлт гарахад бас хувь нэмэр болсон уу? гэх мэт.

- **Бодит өөрчлөлт мөн үү?**

Нөлөөллийн үр дүнд бий болсон өөрчлөлтийг дүгнэж үзэхдээ зөвхөн бодитой үзүүлж буй нөлөөг нь үндэслэх нь оновчтой. Тухайлбал, батлагдсан шинэ

хууль нөхцөл байдлыг сайжрахад нөлөөлж чадаж байна уу? Үнэхээр бодитой хэрэгжиж чадаж байна уу?

- **Шууд ба шууд бус үр дүн**

Нөлөөллийн хүрээнд зохион байгуулсан ажлуудаас үүдэлтэй төлөвлөгдөөгүй үр дүн гарч болох бөгөөд хийсэн ажлынхаа үр дүнг хэмжихдээ тэдгээрийг тооцох нь чухал. Тухайлбал, нөлөөллийн тодорхой зорилтдоо хүрч хараахан чадаагүй ч, таны хийсэн ажлын үрээр тухайн тодорхой асуудал, нөхцөл байдлын талаар иргэний нийгмийн бусад байгууллагууд тодорхой ойлголт мэдээлэлтэй болж, улмаар нэгдэн тусдаа нөлөөллийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжүүлэх тохиолдол гарч болох юм.

Нөлөөллийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжүүлсэн хоёр байгууллагын жишээг эцэст нь энд өгүүлье. Нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад зорилгоо зөв тодорхойлон, зорилгодоо хүрэх стратегийг оновчтой боловсруулж, нөлөөллийн үйл ажиллагааг цогцоор, тодорхой үе шаттайгаар хамтын хүчээр явуулбал амжилтанд хүрч болдгийг эдгээр жишээ харуулж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг санаачлан батлуулсан нь

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв /ХЭҮТ/-өөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг санаачлан батлуулсан нь тэдний нөлөөллийн амжилтын гэрч болон эдүгээ Монгол Улсад хэрэгжиж буй билээ. 2004 оны 05 сарын 13-нд уг хууль батлагдсанаар Монгол Улсын иргэдийн хүчирхийллийн айдсаас ангид амьдрах эрхийг баталгаажуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал зөвхөн ТББ-уудын сайн дурын үүсгэл санаачилгын үндсэн дээр хийгдэх ажил бус төрийн оролцоо, зохицуулалт, үүрэг, хариуцлага шаардлагатай болохыг харуулсны зэрэгцээ, энэ талаар эрх зүйн орчныг бүрдүүлснээрээ ач холбогдолтой. Ингэснээр энэхүү сөрөг үзэгдэлтэй тэмцэхээс гадна хохирогчдод үйлчлэх арга хэмжээний тогтолцоо, механизмыг бүрдүүлэх эхлэлийг тавьсан билээ. Иргэний нийгмийн санаачилгаар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг батлуулсан энэ амжилттай түүх нь эрх зүйн орчныг боловсронгуй болгон хөгжүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг тодорхой зорилго стратегид үндэслэн хэрэгжүүлбэл амжилтанд хүрч болдгийг харуулсан бодит жишээ юм.

Бэрхшээл, сорилт, боломжууд

ХЭҮТ-өөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуультай байх шаардлагатай хэмээн ухуулга сурталчилгаа хийж байсан бүхий л хугацааны турш Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль (ЭБШХ), Захиргааны хариуцлагын тухай хууль байхад бие даасан хууль хэрэггүй хэмээн үзэх үзэл түгээмэл хүчтэй байсан. Иймээс уг хуулийг санаачилж, амьдралд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг ойлгуулахын тулд ХЭҮТ-өөс дээр дурдсан хуулиуд нь гэр бүлийн хүрээнд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй таслан зогсоход яах аргагүй хангалттай биш байгааг нотлох шаардлага гарч иржээ. Тухайлбал:

- Хүчирхийлэлтэй харьцааны түүхийг бус харин хүчирхийллийн үйлдлийг тухайн өдөр, цагт нь авч үздэг;
- Айдастай хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй нүүрэлдүүлдэг;
- Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад бус хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэхэд анхаарлаа хандуулдаг;
- Хохирогчийг хэргээ өөрөө танилцуулж, хөөцөлдөх байдалд оруулдаг;
- Торгууль, хариуцлагын үр дагаврыг хохирогч өөрөө үүрдэг;
- Хохирогчийг хэргээ өөрөө нотлохыг шаарддаг;
- Хүчирхийлэл үйлдэхэд хүргэж буй үзэл бодолд нь нөлөөлөх арга хэмжээ хомс;
- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг шууд гэмт хэрэгтэн болгохыг хүсдэггүйгээс Эрүүгийн хуулийн хамгаалалтыг авч чадахгүй байсан зэрэг тодорхой дутагдлуудыг гарган тавьжээ.

Түүнчлэн ХЭҮТ-өөс нөлөөллөө амжилттай хэрэгжүүлэхэд дараах боломжуудад дөрөөлөх боломжтой байсан юм. Үүнд:

- Төрийн зарим бодлого, хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар зорилтууд урьдчилан тусгагдсан байв. Тухайлбал: Жендерийн тэгш байдлын үндэсний хөтөлбөр, Гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого, Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- 2004 оныг Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил болгон Засгийн газраас зарласан;
- УИХ өөрөө санаачилга гарган гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчинг судлах ажлын хэсэг байгуулсан;
- Азийн сан зэрэг олон улсын байгууллагуудын зүгээс арга зүйн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн,
- Тухайн жил нь сонгуулийн жил байсныг ашиглах зэрэг.

Гэхдээ дараах тодорхой бэрхшээлүүд тулгарсан. Үүнд:

Хууль зүйн байнгын хорооны ихэнх гишүүд Эрүүгийн болон ЭБШХ гэх мэт суурь хуулиудын үзэл баримтлалтай зөрчилдөж байна гэж үзэн эсэргүүцсэн явдал олон гишүүдийг эргэлзээнд оруулсан. Энэ хуулийн төсөлд тусгагдсан хамгаалалтууд нь Монгол Улсын хууль тогтоомжид шинэ зохицуулалт хийх шаардлага бий болгож, тэднийг эргэлзэх, эсэргүүцэхэд хүргэж байв.

Тухайлбал, бусад хуулиудад орох нэмэлт өөрчлөлтийн талаар саналыг гишүүд ихээхэн шүүмжилж байв. Учир нь Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний ба Иргэний хэрэг хянан шийдвэрлэх гол суурь хуулиуд шинэчлэгдэн 2002 оны 9 сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд удаагүй байхад энэ хуулиар өөрчлөх болох нь хэмээн үзэж байв. Жишээлбэл: уг хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийллийн хэрэгт эвлэрүүлэх арга хэмжээ авахгүй байхаар тусгагдсан нь Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үзэл баримтлалыг зөрчсөн гэсэн эсэргүүцэлтэй тулгарч байлаа. Энэ нь зарим гишүүдийг эргэлзээнд оруулж, хуульч гишүүд ингэж үзэж байхад хуулийн төслөө зүтгүүлээд байх юм хэмээн зэмлэж, хуулийн төслөө татаж авахыг санал болгох, зөвлөх, шаардах байдалд хүргэж байсан юм.

Түүнчлэн хууль тогтоогчдын зүгээс шинэ хуулийг гэр бүлийг бутраах, задлах хууль болох вий хэмээн болгоомжилж байсан. Парламентын эрэгтэй гишүүд асуудалд хүний эрхийн үүднээс хандахын оронд эр хүний нүдээр, эр хүний үзэл хандлагаар харах тохиолдол ч гарч байв. Тухайлбал, гаднаас хуулбарласан, Монголын хөрсөнд тохироогүй гэж үзэх хандлага ажиглагдаж байсан ба ганц алгасаны төлөө хүчирхийлэл үйлдэгч гэж нэрлэн, эрхийг нь хязгаарлаж болохгүй гэх зэрэг хариу өгөх тохиолдол байв.

Улсын Их Хурлаар хуулийн төслийг батлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан нь:

Эвсэн ажиллах тактик: Гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал гэсэн халхавчин доор оруулан ойшоохгүй байгааг бодитой илрүүлэн, хүний аюулгүй байх, халдашгүй чөлөөтэй байх үндсэн эрх зөрчигдөж байгааг ил гарган тавьж, нийгмийн тулгамдсан асуудал болохыг олон нийт болон шийдвэр гаргагчдад ойлгуулахаар нөлөөлөх үйл ажиллагааг эхлүүлсэн юм. ХЭҮТ-өөс гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх явцад олж илрүүлсэн хуулийн хийдэл, цоорхойд анализ хийж, төрийн зүгээс эрх зүйн зохицуулалтын оновчтой шийдэл шаардагдаж байгааг баримтаар нотлон шахалт үзүүлэх үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар тасралтгүй хийсэн. Дээрх үйл ажиллагаанууд яваандаа тодорхой зохион байгуулалтанд шилжин нэг эрх ашиг, сонирхол бүхий байгууллага, хувь хүмүүс нэгдэн, нэг ижил зорилго, стратеги, тактикийгаар нөлөөлөл, лобби үйл ажиллагааг өрнүүлэх болсон юм. Энэхүү зохион байгуулалттай бүлэг нь хуулийн төсөл боловсруулах, нөлөөлөх, өртөг зардлыг тооцох гэсэн гурван бүлэгт хуваагдаж, нэгдсэн зорилгоо тодорхойлж, хэрхэн ажиллах стратеги, тактикаа ажлын хэсгүүдийн хуралдаанаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар батлан гаргаж түүнийгээ баримтлан ажилласан билээ.

Стратеги боловсруулан хэрэгжүүлсэн нь: Хэд хэдэн гол стратегийг үндсэн 2 чиглэлээр хэрэгжүүлсэн. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн талаар бие даасан хууль байх шаардлагатай гэсэн үзэл бодол, шаардлагыг нийгэмд бий болгох: Шашин, уламжлалыг үндэс болгон ухуулах, олон нийтийн оролцоог дайчлах, тэдний дэмжлэгийг авах, “Зүрх сэтгэлийг хөдөлгөх” баримтыг ил гарган үзүүлэх, нийгэмд нэр нөлөө бүхий хүмүүсийн хандлага, үзэл бодлыг танилцуулан ухуулах
- УИХ-д хуулийн төслийг өргөн барьж хэлэлцүүлэн батлуулах: Хамгаалах байраар үйлчлүүлэгч, хохирогч эмэгтэйчүүдийг чадавхижуулах замаар тэдний дуу хоолойг хууль тогтоогчдын сонорт хүргэх, тойргийн сонгогчдоор дамжуулан нөлөөлөх, эсэргүүцэж байгаа болон эргэлзэж байгаа гишүүдтэй ганцаарчилсан лобби хийх, УИХ-ын аль болох олон гишүүнээр хуулийн төслийг өргөн бариулах, төр засагт хүлээсэн үүргийг нь сануулах, шахалт үзүүлэх, хуулийн төслийн гол амин сүнс болсон зохицуулалт, зүйл, заалтуудыг хэвээр нь авч үлдэх бодлого барьж, түүнийг батлан тайлбарлах үндэслэл, няцаалтыг бэлтгэх
- Үүнээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглаж бие даасан хууль байх шаардлагатай гэсэн илгээлтийг олон нийт болон хууль тогтоогчдын аль алинд нь хүргэж чадсан.

Зайлшгүй анхаарах практик асуудлууд:

Хууль батлагдана гэдэг нэг хэрэг, хамгийн чухал нь хуулийг хэрэгжүүлэх арга зүйг бий болгох, хууль хэрэгжих механизмыг бүрдүүлэх явдал одоо нэн чухлаар тавигдаж байна.



Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад олон нийтийн оролцоог хангах заалтуудыг оруулах нөлөөллийн үйл ажиллагаа

Хүний эрх хөгжил төв 2004 оноос стратегийн өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Стратегийн өмгөөллийг уул уурхайн бүсэд амьдарч буй иргэдийн зөрчигдсөн нийтийн эрх ашгийг хамгаалах зорилготойгоор явуулж эхэлсэн. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд холбогдох холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдэд орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах механизмыг тодорхой болгох хэрэгтэй гэсэн санал, дүгнэлтийг төслийн баг гаргасан юм. Ингээд төслийн баг 2006 оны УИХ-ын хаврын чуулганаар шинэчлэн найруулга хийгдэхээр болсон **Монгол улсын Ашигт малтмалын тухай хуульд** олон нийтийн оролцоог хангах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой заалтуудыг оруулах нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

- ☑ **Асуудлыг тодруулах:** Орон нутгийн иргэдийн эрх, эрх ашиг хэрхэн, яагаад зөрчигдөж байна?

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн байгаль орчны сүйтгэл, түүнээс улбаатай нутгийн иргэдийн хүний эрхийн зөрчлийг баримтжуулан олон нийт, шийдвэр гаргагчид, холбогдох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагуудын анхааралд хандуулах, зохих асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд дараах ажлуудыг хийсэн:

- Монгол дахь НҮБ-ын Хүний эрхийн бүлгийн хурал дээр уул уурхайн бүсэд амьдарч буй иргэдийн эрх ашиг хэрхэн зөрчигдөж байгаа, үүний улмаас орон нутгийн иргэд, уул уурхайн компаниудын хооронд зөрчил үүссэн тухай танилцуулав. Энэ хурлаас НҮБ-ын Суурин Төлөөлөгчийн Газар, НҮБ-ын Хүний эрхийн бүлэг хамтран уул уурхайн салбарт гарч байгаа хүний эрхийн асуудлыг судлах, үндэсний хэлэлцүүлэгт зориулсан баримт бичиг бэлтгэх ажлыг Хүний Эрх Хөгжил төвөөр гүйцэтгүүлэхээр тогтов.
- Хэлэлцүүлгийн баримт бичгийн гол зорилго нь уул уурхай ба хүний эрхтэй холбоотой зангилаа асуудлуудыг тодорхойлоход оршиж байлаа. Хэлэлцүүлгийн баримт бичгийг гаргахдаа оролцогч бүх талуудын ашиг сонирхлыг хүндэтгэж, хүний эрх ба байгаль орчныг хамгаалах асуудлыг уул уурхайн салбарын хөгжилтэй хэрхэн зохистойгоор уялдуулах тухай тэдний санаа бодлыг тусгах зарчмаар ажиллав.
- Хэлэлцүүлгийн баримт бичигт уул уурхайн салбарт оролцогч олон талын бүтээлч хамтын ажиллагааг бий болгох замаар энэ салбар дахь байгаль орчин ба хүний эрхийн асуудлыг амжилттай шийдвэрлэж байгаа бусад орны туршлагыг тусган харуулсны зэрэгцээ Монгол улсад уул уурхайн хөгжлийг хэрхэн байгаль орчин, хүний эрхийн асуудалтай зохицуулж болох талаар зөвлөмж боловсруулан оруулав.

- Уг хэлэлцүүлгийн баримт бичгийг Ерөнхийлөгчийн ивээл дор зохион 2006 оны 5 сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан “Уул уурхай, эрх зүйн зохицуулалт, байгаль орчин” сэдэвт үндэсний зөвлөгөөний хүний эрхийн салбар хуралдаанд тавьж хэлэлцүүлсэн бөгөөд эндээс гарсан зөвлөмжид тус хуралдаанд оролцогсод саналаа боловсруулж тусгуулан шийдвэр гаргагчдын анхааралд хүргүүлэв.

Ерөнхийлөн авч үзвэл, байгаль орчинтой холбоотой эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр, төслийг /тухайлбал, ашигт малтмалаа ашиглах/ боловсруулах, батлахдаа иргэд олон нийтийн оролцоог албан ёсоор хангаагүй байв.

☑ **Хамтран ажиллах тактик:**

Монгол улсын уул уурхайн салбарын үйл ажиллагааг хариуцлагатай болох зорилгоор энэ чиглэлээр ажиллаж байгаа байгууллагууд хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаад анхаарлаа хандуулан **Хүний эрх хөгжил төв, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, Нутаг усаа хамгаалах голуудын хөдөлгөөн** нэгдэн “Хариуцлагатай уул уурхайн төлөөх хамтын ажиллагааны гэрээ”-г 2006 оны 5-р сарын 18-нд байгуулав.

☑ **Асуудлыг олон нийтийн анхаарлын төвд хүргэх:**
“Хариуцлагагүй уул уурхайгаас Хариуцлагатай уул уурхай руу”

Гэрээний гурван тал олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монгол улсын уул уурхайн одоогийн практик **“хариуцлагагүй”** байгаа бөгөөд энэ байдлыг хэрхэн **“хариуцлагатай”** болгон өөрчлөх тухай өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн нийтлэл, мэдээллүүдийг нийтлүүлэх, телевизийн ярилцлагад оролцох зэргээр ажиллав. Тухайлбал: Хүний эрх, хөгжил төвийн хариуцлагатай уул уурхайн талаарх үзэл бодлыг илэрхийлсэн “Хариуцлагагүй уул уурхайгаас хариуцлагатай уул уурхай руу” сэдвээр Өнөөдөр сонинд өгүүлэл нийтлүүлж, Ийгл телевизийн мэдээний ярилцлага болон радиогоор ток шоунд оролцов.

☑ **Мэргэжилтнүүдийн туслалцаа:**

Ашигт малтмалын тухай хуульд оруулах заалтуудыг боловсруулах ажлыг “Хүний Эрх-Хөгжил” төв хариуцан ажиллав. Энэ үйл ажиллагаанд олон улсын болоод дотоодын мэргэжилтнүүдийн туслалцаа ихээхэн чухал байсан. Олон улсын тэргүүн туршлага, эрх зүйн баримт бичгүүд, тэдгээрийг Монголын нөхцөлд хэрхэн ашиглаж болох тухай мэргэжилтнүүдийн зөвлөгөө энэ шатны гол цөм байлаа. Хуульд оруулах саналын гол зорилго нь байгаль орчинтой холбоотой хөгжлийн төсөл боловсруулан хэрэгжүүлэхэд олон нийтийг шийдвэр гаргах үйл явцын албан ёсны нэг тал болгон оролцуулах механизмыг уг хуульд суулгах ёстой гэсэн үндсэн зөвлөгөөг мэргэжилтнүүд гаргасан юм. Энэ механизмыг тодруулахын тулд тулгуур үндсэн зарчмуудыг гаргаж, тэдгээрийг хангасан хуулийн заалтуудыг боловсруулав:

- Уул уурхайн үйл ажиллагааны холбогдох баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох
- Лицензтэй холбоотой шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог бодитойгоор хангах
- Байгаль орчны үнэлгээ, түүнийг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд иргэдийн хяналт, оролцоог бүрдүүлэх,
- Уул уурхайн төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн эрх ашгийг хүндэтгэн, хэрвээ энэ нь хөндөгдөх бол хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхой болгох
- Хайгуулын болон ашиглах лиценз эзэмшигчийн байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлтийг чанаржуулах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зэрэг болно.

☑ Лобби үйл ажиллагаа

Үйл ажиллагааны тактикийг боловсруулав: ХЭХТөв, Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Нутаг усаа хамгаалах голуудын хөдөлгөөн нь боловсруулсан заалтуудаа хуульд суулгах тактикаа тодорхойлох, зөвлөлдөх уулзалтыг хийж дараах байдлаар саналаа УИХ-ын гишүүдийн анхааралд хүргэхээр төлөвлөв:

Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага
УИХ-ын бүх гишүүдэд өөрийн боловсруулсан саналаа и-мэйл хаягаар хүргүүлэх	Хүний Эрх хөгжил төв
Хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүдэд саналыг, уриалга бичигтэй хүргүүлэх	Нутаг усаа хамгаалах голуудын хөдөлгөөний гишүүн 14 байгууллага нь өөрийн орон нутгаас сонгогдсон гишүүдэд саналыг хүргэж, цаг аван уулзаж ярилцах, дэмжлэг хүсэх
Дэмжигч гишүүдийг илрүүлэн тулж ажиллах	ХЭХТ, Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн тэргүүнүүд, хөтөлбөрийн ажилтнууд дэмжигч гишүүдийг илрүүлэн, тухайн заалтуудаа хуульд тусгуулж оруулах зорилготой уулзалтуудыг зохион байгуулав.
<p>ХЭХТ-ийн хүний эрхийн нөлөөллийн баг хэлэлцэгдэж байгаа төслийн хувийг УИХ-ын чуулганы хуралдааны маргааш өдөрж нь олж авч, өөрсдийн боловсруулсан заалтууд хэрхэн тусгагдсан болон тусгагдаагүй орхигдсоныг шалган тогтоож, санал аваагүй гол шалтгааныг нь дэмжигч УИХ-ын гишүүнээс лавлан мэдэж, дараагийн өдрийн лобби үйл ажиллагааг төлөвлөн УИХ-ын ямар гишүүнтэй уулзах, аль заалтаа хэрхэн дэмжүүлэхээ нарийн тооцон ажиллаж байлаа. Мөн тухайн заалтаа дэмжүүлэх үндэслэл, нотолгоо, баримтыг бэлтгэж, дэмжигч гишүүддээ хугацаа алдалгүй хүргүүлдэг байв.</p>	

☑ **Үр дүн:**

Дээрх зорилтуудын хүрээнд хуульд оруулах заалтуудыг боловсруулан лобби ажлыг хийж зохих амжилтанд хүрсэн юм. Лобби ажлын үр дүнд тус хуулийн шинэчилсэн найруулгад нутгийн захиргааны байгууллагатай харьцах тухай 42 дугаар зүйлийн 1 ба 3 дугаар заалт, мэдээлэл болон төлбөрийн хуваарилалт, нөхөн төлбөр, санхүү бүртгэлийн онцлогийн тухай 57 дугаар зүйлийн 4 дүгээр заалтууд нь тус багийн томъёолсноор хуулинд тусгагдсанаас гадна, мөн олон заалтууд нь тус төвийн боловсруулан санал болгосон агуулгаар орсон. Өөрөөр хэлбэл:

- Холбогдох мэдээлэл иргэдэд нээлттэй болов
- Тусгай зөвшөөрөл буюу лиценз олгох үйл явцад орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн иргэдийн оролцоог албан ёсоор баталгаажуулав
- Байгаль орчны үнэлгээ, түүнийг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд иргэдийн хяналт, оролцоог хангав,
- Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч ба орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын гэрээ буюу оролцооны гэрээг байгуулах боломжтой болов
- Хайгуулын болон ашиглах лиценз эзэмшигчийн байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг чанаржуулах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэв.

Ашигласан ном, материал

Nowicki, Marek and Zuzana Fialova. 2004. Human Rights Monitoring. Warszawa: Helsinki Foundation for Human Rights.

Holloway, Richard. NGO Corruption Fighters' Resource Book –how NGOs can use monitoring and advocacy to fight corruption. New York: Justice Initiative, Open Society Institute

Guzman, Manuel and Bert Verstappen. 2003. What is Monitoring. Vol 1. Versoix [Switzerland]: HURIDOCs

Qualitative Research, Quantitative Research. Focus Group. Case Study. Wikipedia. <http://www.wikipedia.org/>

Advocacy: Building Skills for NGO Leaders. 1999. The CEDPA Training Manual Series. Vol IX. Washington D.C. : The Center for Development and Population Studies

Улс Төрийн Боловсролын Академийн Лекцийн Эмхтгэл. 2001 он. Улаанбаатар: Улс Төрийн Боловсролын Академи

Төрийн Үйлчилгээний Мониторинг: ТББ-уудын Мониторингийн Тайлангийн Эмхтгэл. 2006. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум

Стратегийн өмгөөлөл: Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь. 2006 он. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум

Мэдэх эрх. 2003 он. Улаанбаатар: Глоб Интернэйшнл ТББ

Working for Change in Education: A handbook for planning advocacy. Save the Children

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН